



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“ТЭРБУМ МОД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС
ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД: БНА-2025/34-ШТА-ГА

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр тарьсан модны арчилгаа, усалгаа, хамгаалалт хангалтгүй, хөрсний онцлогт тохироогүй төрөл сонгосноос ургалтын хувь буурч, төсвийн хөрөнгийн үр ашиг алдагдах эрсдэлтэй байна.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер **М.Алтантуяа**

Утас: 70442424 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Цахим хуудас: doljmaab@audit.gov.mn

Аудитор Д.Цэдэвцэвээн

Цахим хуудас: tsedevtseveend@audit.gov.mn

Аудитор А.Адилзаяа

Цахим хуудас: adilzayaa@audit.gov.mn

Аудитор Г.Энхзул

Цахим хуудас: enkhzulg@audit.gov.mn

Аудитор Д.Оюун-Эрдэнэ

Цахим хуудас: oyunerdenede@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АХТЖҮЧ	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОГ	Байгаль орчны газар
БОНХОБТХ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
БХНСАХЗ	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХТ	Засаг даргын үйл ажиллагааны хүрэх түвшин
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НҮТББ	Нийтийн Үйлчилгээний Төрийн Бүс Байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТББ	Төрийн бүс байгууллага
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮХ	Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс
ШУА	Шинжлэх ухааны академи

Хүснэгтийн жагсаалт

№	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улс, орон нутгийн төсвөөс батлагдсан санхүүжилтийн эх үүсвэр (сая.төг)	7
Хүснэгт 2	Баянхонгор аймгийн 2022-2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний нэгтгэл (сая.төг)	7
Хүснэгт 3.	БОГ-аас аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн албан бичгийн нэгтгэл (сая.төг)	8
Хүснэгт 4	20 сая мод тарих төлөвлөгөө-Зорилтоор	8
Хүснэгт 5	Баянхонгор аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний нэгтгэл	8
Хүснэгт 6	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарихаар төлөвлөсөн, тарьсан модны тоо	20
Хүснэгт 7	Тарьц, суулгац ургуулсан иргэдэд олгосон ажлын урамшуулал (сая.төг)	25
Хүснэгт 8	2022-2025 онд тарьсан модны тоо мэдээ	30
Хүснэгт 9	Баянхонгор аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлсэн байдал (2022-2025 оны хагас жил)	31

Хүснэгт 10	Засгийн газрын тэргүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ, Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх журмын 5.3.3-ын дагуу үнэлсэн байдал (Ногоон байгууламж 2022-2025 оны хагас жил)	32
Хүснэгт 11	Ойжуулалттай холбоотой төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгүүд (сая.төг)	34

Дүрслэлийн жагсаалт

№	Агуулга	Хуудасны дугаар
1	Санал асуулгын дүн	33
2	Баянхонгор аймгийн хэмжээнд <i>terbunmod.mn</i> сайтад мод бүртгэсэн байдал	36

Хавсралтын жагсаалт

№	Агуулга
1	Мод тарих амлалтууд
2	БОГ-ын нэгтгэлээр тарьсан модны тоо
3	Баянхонгор аймгийн БОГ-т 2024, 2025 оны сумдаас ирүүлсэн сургагч багшийн тайлангийн нэгтгэл
4	Сумдаас ирүүлсэн судалгаа болон БОГ-аас ирүүлсэн судалгаагаар тарьсан модны тоо байршлаар (2022-2025 оны хагас жил)
5	Сумдын засаг даргын гэрээний хэрэгжилтээр тарьсан модны тоо (2022-2025 оны хагас жил)
6	Аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийн хувь
7	Засгийн газрын тэргүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ, сумдаар (1.Ногоон байгууламж 2022-2025 оны хагас жил)
8	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд уул уурхайн компанийн 2022-2025 онд тарьсан модны судалгаа
9	Судалгаа-1 “Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд тарьсан модны судалгаа”
10	Судалгаа-2 “Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан санхүүжилтийн судалгаа”
11	Судалгаа-3 “Урамшууллын судалгаа”
12	Судалгаа-4 “Үндсэн хөрөнгийн ашиглалтын судалгаа”

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108, 107 дугаар тушаал, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газар, Баянхонгор аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн болно. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх нэгдсэн бодлогыг орон нутгийн түвшинд төлөвлөсөн эсэх;
2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт үр нөлөөтэй эсэх;
3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Баянхонгор аймаг, сумдын 2022-2024 он, 2025 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал болон тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын аудитад хамаарах үйл ажиллагааг хамруулан, холбогдох байгууллагуудын санхүүгийн баримт материал, судалгаа, тайлангийн хүрээнд гүйцэтгэлээ. Аудитын баг 20 сумаас түүвэрлэн Богд, Шинэжинст, Бууцагаан, Баян-Овоо, Өлзийт, Эрдэнэцогт сумдад томилолтоор ажилласан.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал-ын дагуу аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, ярилцлага, судалгаа хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль;
- Иргэний хууль;
- Ойн тухай хууль
- Газрын тухай хууль

- Хот байгуулалтын тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг
- Монгол улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Гэмт хэргээс, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 03 дугаар сарын 14-ний 01 дүгээр тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 дүгээр тушаалаар баталсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журам
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2015 оны А-140/63 дугаар тушаалаар баталсан “Ойг хамгаалах, тарьц, суулгац ургуулах ажлыг урамшуулах журам”
- Төсөл, арга хэмжээний баталсан зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтууд
- Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд;
- Ажил гүйцэтгэх гэрээ, хүлээн авсан акт

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа хэрэгжүүлэн, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Д.Цэдэвцэвээн, Г.Энхзул, А.Адилзаяа, Д.Оюун-Эрдэнэ нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

- Аудитын хамрах хугацаа нь 2022 оноос хойш хугацааг хамарсан, 2022-2023 онд тарьц, суулгац тарьсан, түүнийг актаар хүлээн авсан боловч хүлээн авсан хугацаанаас хойших усалгаа, хамгаалалтыг хариуцах хүнгүй эзэнгүйдсэнээс дийлэнх тарьц суулгац ургаагүй, ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссан байна.
- Цаг агаарын хуурайшилттай холбоотой зарим сумд мод шарлаж унасан, эрт унтаа байдалд орсон нь модны ургалтын хувийг тогтооход мэргэжлийн хүн зайлшгүй шаардлагатай байсан болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд оролцохдоо “Монгол улс 2030 он гэхэд тэрбум мод ургуулахаар төлөвлөсөн”-ийг зарласан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн гаргасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн

тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж, хэрэгжүүлэхийг зарлиг болгосон байна.

Дээрх зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 350 дугаар тогтоолоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээ, Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 03 дугаар сарын 14-ний 01 дүгээр тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталжээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан хамгаалж, ургуулснаар ойн санг 9.0 хувьд хүргэж, цөлжилт, газрын доройтлыг бууруулж, хүлэмжийн хийн шингээлт, усны нөөцийг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сайжруулж, ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх” эрхэм зорилго тавьсан байна.



Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг 2021-2030 онд хэрэгжүүлснээр улсын хэмжээнд 2022-2024 он хүртэл 150.0 сая, 2027 он хүртэл 850.0 сая, 2030 он хүртэл нийт 1.0 тэрбум мод тарихаар төлөвлөснөөс дээрх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 3.3.5-т заасны дагуу 67.0 сая модыг Хил хамгаалах Ерөнхий газар болон 7 аж ахуйн нэгж тарьж өгөхөөр амлан, аймагт 20.0 сая модыг тарихаар хуваарилснаар, нийт 87.0 сая модыг тарихаар төлөвлөжээ. Баянхонгор аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарихаар амласан 20.0 сая модыг сум бүрд 1.0 сая модыг тарихаар төлөвлөсөн ч он тус бүрд тарих модны тоог төрлөөр, хөрсний онцлог, байгаль цаг уурын онцлогт тохируулан бодитой төлөвлөөгүй байна.

Аудитаар авсан судалгаагаар Баянхонгор аймгийн хэмжээнд амлалт өгсөн Хил хамгаалах Ерөнхий газар болон 7 аж ахуйн нэгж мод тариагүй ба улс, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр, Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 12 уул уурхайн аж ахуйн нэгж, айл өрх, албан байгууллагууд 517,725 ширхэг модыг тарьсан нь амласан нийт модны 2.59 хувийг биелүүлсэн ба улсын нэгдсэн санд тарьсан модыг бүртгээгүй байна.

Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу Баянхонгор аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг батлуулаагүй.

Байгаль орчны тогтвортой байдлыг хангах зорилгоор ойн эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, нөөцийн хомсдол, доройтлыг зогсоох, нөхөн сэргээх замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, ойн тогтвортой менежментийг бий болгох төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн болон удирдлагын өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэх эрхэм зорилгын дор Засгийн газрын 2022 оны 272 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар /цаашид Ойн газар гэх/ байгуулагджээ.

БОАЖС-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/654 дугаар тушаалаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги төлөвлөгөөнд туссан ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2024 оныг “Ойн жил” болгон зарлажээ.

Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 06 дугаар тогтоолоор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг аймгийн Байгаль орчны газар болгон өөрчилсөн байна. (цаашид БОГ гэх)

Ойн санг хамгаалах, хортон шавжтай тэмцэх нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний салшгүй хэсэг бөгөөд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 2024-2025 онд 19694 га талбайд 1,367.7 сая төгрөгийг улсын төсвөөс зарцуулан хортон шавжтай тэмцэх ажлыг хийснээр модыг хортон шавжид өртөх, ургах чадвараа алдахаас хамгаалж чадсан байна.(Аймгийн БОГ-ын танилцуулгаас)

Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.23¹-т заасны дагуу Баянхонгор аймагт мод үржүүлэг, ойжуулалт, нөхөн сэргээх үйл ажиллагаа эрхэлдэг “Их хайрханы хаялга” ХХК, “Бөмбөгөр хайрханы төгөл” ХХК, “Си тү трий” ХХК, “Түйн голын төгөл” ХХК зэрэг мэргэжлийн 4 байгууллага Ойн газраас зөвшөөрөл авч ажиллаж байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд нийт 7 мод үржүүлгийн газартай, үүнээс “Их хайрханы хаялга” ХХК нь хувийн хэвшлийн бөгөөд Сум дундын ойн анги, Шинэ суурьшлын бүсийн Мод үржүүлгийн газар, Богд, Жаргалант, Эрдэнэцогт, Баян-Өндөр сумдын Мод үржүүлгийн газар ажилладгаас Сум дундын Ойн анги нь орон нутгийн төсвөөс санхүүжиж, Богд сумын Мод үржүүлгийн газрын харуул хамгаалалтын зардлыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр аймгийн БОГ-ын төсвөөс олгож байна.

¹ Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох;

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ СТРАТЕГИ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-Г БАТЛААГҮЙ БАЙНА.

1.1. “Тэрбум мод” үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулахыг 2023 онд аймгийн Засаг дарга, ИТХ-аас аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт даалгасан байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.1.1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 58 дугаар зарлигийг гаргаж энэхүү зарлигт “Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах Монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж, 5 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг” чиглэл болгосон.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2020-2024, 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын 6.2.1, 6.2.2, Шинэ сэргэлтийн бодлогын 5.1, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4, 3.4.1.4, Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.1.4 зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан Баянхонгор аймгийн 2022-2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлуудыг тусгасан байна.

Жил бүр аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд ногоон хөгжлийн бодлогын “Эх байгаль-Ногоон байгууламж” арга хэмжээний хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тодорхой заалтуудыг тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажилласан бөгөөд 2022–2025 онд нийт Аймгийн Засаг даргын 6 захирамж, 2 албан даалгавар гарч, захирамж болон албан даалгаврын биелэлтийг тооцон ажилласан байна.

1.1.2. Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг үндэсний хорооны гишүүд, яамд Засгийн газрын байгууллагууд, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосон байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа–2050”, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Уур амьсгалын Үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г үндэслэн аймгийн БОАЖГ-аас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулсныг аймгийн ИТХ-аас хэлэлцээгүй буцаасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн БОАЖГ 2023 онд боловсруулсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө”-г аймгийн ИТХ-ын дэргэдэх Байгаль орчин, хүнс, хөдөө, аж ахуйн асуудал эрхэлсэн хорооны 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэх асуудалд оруулсан боловч хорооны гишүүдийн олонхын саналаар хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг тодорхой болгож, мэдээллийг сайжруулан, эргэн танилцуулахаар хойшлогдсон байхад тус стратеги төлөвлөгөө одоо болтол сайжруулан батлуулаагүй байна.
- Баянхонгор аймгийн БОАЖГ-аас боловсруулсан дээрх төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүд нь тодорхой бус, тоон мэдээллүүдийг ойлгомжгүй, зөрүүтэй илэрхийлсэн байна.

Шийдвэрлэлт: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд Уур амьсгалын Үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор “Тэрбум мод” үндэсний

хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г үндэслэн аймгийн БОАЖГ-аас тус стратеги төлөвлөгөөг аймгийн хэмжээнд батлах зайлшгүй шаардлагатай байгааг аймгийн ИТХ-д толилуулав.

1.1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ойжуулалтын арга хэмжээг төлөвлөх, талбайн байршлыг сонгохдоо сумдын Засаг дарга, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн газрын кадастрын зураг, координатын хамт сумдын ЗДТГ-аас аймгийн БОГ-т хүргүүлж, БОГ сумдын саналуудыг нэгтгэн Ойн газарт хүргүүлсний дагуу Ойн газар шийдвэр гаргаж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг анх хэрэгжүүлэхээр 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн “Ойн анхдугаар чуулган”-ыг зохион байгуулах үеэр бүх сумдын удирдлага, салбарын төлөөллийг цуглуулан хэрхэн яаж, хэрэгжүүлэх талаар хэлэлцэж байжээ.

Жил бүр аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх ойжуулалтын арга хэмжээний саналыг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ээс сум бүрээс албан бичгээр авсан байна.

1.1.4. Баянхонгор аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд улс, орон нутгийн төсвөөс 2022-2024 он, 2025 оны эхний хагас жилд нийт 7,235.6 сая төгрөгийг олгохоор баталжээ.

Хүснэгт 1. Улс, орон нутгийн төсвөөс батлагдсан санхүүжилтийн эх үүсвэр (сая.төг)

Он	Санхүүжилтийн эх үүсвэр						Нийт дүн
	Улсын төсвөөс санхүүжүүлсэн	Орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн	БХНСАХЗ-аар санхүүжүүлсэн	Баянхонгор аймгийн сум дундын ойн анги	Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	
2022	944.5	63.4	297.5	436.9	107.2	167.2	2,016.8
2023	306.0	120.4	612.2	236.8	152.9	10.1	1,438.2
2024	787.4	346.9	650.2	134.9	304.4	14.4	2,238.2
2025	326.8	217.4	458.0	301.0	222.4	16.9	1,542.4
Нийт	2,364.6	748.1	2,017.8	1,109.6	786.8	208.7	7,235.6

Эх сурвалж: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянхонгор аймгийн хэмжээнд 2022-2025 онд тарьсан модны санхүүжилтийн эх үүсвэрийн дэлгэрэнгүй судалгаа 2

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр Баянхонгор аймгийн 2022-2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд нийт 2,116.7 сая төгрөгийн 12 зорилт, арга хэмжээг тусгасныг үр дүнтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Баянхонгор аймгийн 2022-2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний нэгтгэл (сая.төг)

Он	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээний тоо	Зардлын дүн
2022	Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх тухай зарлиг, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.6.6, 5.1.8 дахь заалт	1	1,000.0
	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Нэг тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөн, Ногоон хэрэм үндэсний хөдөлгөөн	3	215.0
2023	Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх тухай зарлиг, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.6.6, 5.1.8 дахь заалт	1	300.0
2024	АХТЖҮЧ-6.1.4, ЗДҮАХТ-5.1.8	2	159.1
2025	АХТЖҮЧ-6.1.4, ЗДҮАХТ-3.2.1.1	5	442.6
Нийт дүн		12	2,116.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн 2022-2025 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай аймгийн ИТХ-ын тогтоол, хавсралтууд

Баянхонгор аймгийн БОАЖГ 2023-2025 онд 19 арга хэмжээний зардалд 1,819.6 сая төгрөгийн төсвийн төсөөллийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлснээс 2025 оны төсвийн төсөвт Түйн голын хамгаалалтын ойн зурвас байгуулах арга хэмжээг хөгжлийн төлөвлөгөөнд 85.0 сая төгрөгийг тусгасан байна. Энэ талаар аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ээс

тодруулга авахад аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах саналуудыг нэгтгэн удирдлагын багаар хэлэлцүүлж, үр дүнгүй, нэн шаардлагатай биш гэдэг шалтгаанаар дэмжигдээгүй гэсэн тайлбарыг өгсөн болно.

Хүснэгт 3. БОГ-аас аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн албан бичгийн нэгтгэл (сая.төг)

Төсвийн төсөл	БОГ-аас Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажил, арга хэмжээний тоо	Зардлын дүн
2023 оны төсвийн төсөл	2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 319 дугаар албан бичиг	5	135.0
2024 оны төсвийн төсөл	2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 329 дугаар албан бичиг	6	385.0
2025 оны төсвийн төсөл	2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 247 дугаар албан бичиг	8	1,299.6
Нийт дүн		19	1,819.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн БОГ-аас аймгийн CTCX-т 2022-2024 онд хүргүүлсэн албан бичгүүд

1.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд жил бүр тарих модны тоог хөрсний онцлогт тохируулан төлөвлөөгүй байна.

1.2.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг 2021-2030 онд хэрэгжүүлснээр улсын хэмжээнд 2022-2024 он хүртэл 150.0 сая, 2027 он хүртэл 850.0 сая, 2030 он хүртэл нийт 1.0 тэрбум мод тарихаар төлөвлөснөөс “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө-ний 3.3.5-т заасны дагуу Баянхонгор аймагт 67.0 сая модыг Хил хамгаалах Ерөнхий газар болон 7 аж ахуйн нэгж тарьж өгөхөөр амлан, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний 4 зорилтын хүрээнд 20.0 сая модыг тарихаар хуваарилснаар, Баянхонгор аймагт нийт 87.0 сая модыг тарихаар төлөвлөжээ. (Хавсралт 1)

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний 4 зорилтын хүрээнд 2022-2030 онд 20.0 сая модыг тарихаар төлөвлөснөөс Ойн анх дугаар чуулганаар сум бүр 1.0 сая мод тарихаар хуваарилсан байна.

Хүснэгт 4. 20 сая мод тарих төлөвлөгөө-Зорилтоор

№	Зорилт	Тарихаар төлөвлөж буй модны тоо
1	Суурин газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нэмэгдүүлэх, ард иргэдийн амьжиргааны нөхцөлийг сайжруулах, “Хотын ой” хөгжүүлэх;	2,810,675
2	Цөлжилт газрын доройтол, шороон шуурганы эх үүсвэрийг бууруулах, элсний нүүдлийг сааруулах;	6,469,750
3	“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний зорилттой уялдуулан төрөлжсөн агро-ойн аж ахуй хөгжүүлэх	1,801,300
4	Байгалийн ойг нөхөн сэргээх замаар ойн хомсдол доройтлыг бууруулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх;	8,918,275
	Нийт дүн	20,000,000

Эх сурвалж: Байгаль орчны газрын “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2022-2030 он)

Баянхонгор аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд 2022-2023 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны тоо, ургалтын хувийг зааж өгсөн, харин 2024 онд ургалтын хувийг, 2025 онд тарих модны тоо, ургалтын хувийг тодорхой тусгаагүй байна.

Хүснэгт 5. Баянхонгор аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний нэгтгэл

Он	Зорилт арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
2022	“Тэрбум мод” тарих ажлын хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Шинээр тарьж уруулсан модны тоо, ургалтын хувь Хагас бүтэн жилээр тайлагнах	Сум бүр 25.0 мянга, нийт 500.0 мянган мод тарих, ургалт 70-аас дээш хувьтай байна.
2023	“Тэрбум мод” тарих ажлын хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Шинээр тарьж уруулсан модны тоо, ургалтын хувь	Сум бүр 25.0 мянга, нийт 500.0 мянган мод тарих,

		Хагас бүтэн жилээр ургалт 70-аас дээш хувьтай
	тайлагнах	байна.
2024	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх (6 дугаар хавсралт)	Тарьсан модны тоо 425.0 мянган мод тарьсан байна.
2025	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд хамгаалалтын ойн зурвас байгуулах, мод тарих боломжит газрын судалгааг гарган 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулах	Шинээр сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан газрын тоо 1-Тодорхой заагаагүй

Эх сурвалж: Аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай хийсэн гэрээ, гэрээний хавсралт

Аудитын илрүүлэлт:

- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянхонгор аймгийн хэмжээнд 2022-2030 он хүртэлх хугацаанд сум тус бүрд 0.5-1.5 сая мод тарихаар хуваарилсан хэдий ч тус төлөвлөсөн модыг тарихад сум бүрийн он тус бүрд тарих модны тоо хэмжээг тогтоож гаргаагүй байна.
- Аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулсан гэрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024- 2025 онд тарих модны тоо, ургалтын хувийг тодорхой тусгаагүй байна.
- Шинэжинст сумын нийтийн эзэмшлийн 6 хэсэг газарт тарьсан модны ургалт 88.0 хувьтай ба тус газар нь сумын газар зохион байгуулалтын мод тарих төлөвлөгөөнд ороогүй буюу ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй газар байна.

Шийдвэрлэлт:

- Уур амьсгалын Үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г үндэслэн аймгийн хэмжээнд мөрдөх стратеги төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.
- Шинэжинст сумын Засаг даргад цаашид газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу мод тарих талаар зөвлөв.

1.2.2. Баянхонгор аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны төрлийг байгаль цаг уурын орчин нөхцөлд тохируулан төлөвлөөгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 350 дугаар тогтоолын 3²-т заасны дагуу Монгол Улсын Шинжлэх ухааны академиас 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 1/125 дугаар албан бичгээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сум тус бүрийн уур амьсгал, хөрс, бүс бүслүүрт тохирсон ургах боломжтой мод, сөөгийн жагсаалтыг тодорхойлон зөвлөмжийг Баянхонгор аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Дээрх албан бичигт “Мод сөөгийг сонгож тарихдаа тухайн орон нутгийн уур амьсгал, хөрс, газрын гадаргуу, бүс бүслүүрт тохирсон, дасан зохицсон байдлыг харгалзан үзэх нь маш чухал бөгөөд ингэснээр эдийн засгийн хувьд хэмнэлттэй, тарьсан модны амьдралын хувь өндөр, арчилгаа бага шаардах давуу талтай ба тарьсны дараа 3 жил арчилж ургуулснаар цаашид байгальд бие даан ургах боломжтой” гэдэг зөвлөмжийг өгсөн байна.

Ирүүлсэн зөвлөмжийн дагуу Баянхонгор аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (тухайн үеийн нэршил)-ээс сумдын Засаг дарга нарт 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 5/470 дугаар албан бичгээр мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг мод тарих арга хэмжээтэй уялдуулан зохион байгуулж ажиллах талаар чиглэл өгч ажилласан байна.

Аудитаар сумдад тарьсан модны төрлийг ШУА-ийн зөвлөмжийн жагсаалтад байгаа эсэхийг тулгахад Баянговь, Баянлиг, Эрдэнэцогт, Баянцагаан, Бөмбөгөр, Жинст, Заг, Шинэжинст, Өлзийт сум ШУА-ийн зөвлөмжид байхгүй модыг тарьсан байна. Тухайлбал, жагсаалтад багтаагүй модыг тарьсан сумдын хувьд ихэвчлэн айл өрхийн хашаа болон аж ахуйн

² Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга аргачлалд технологийн нэгдсэн зөвлөмж гаргах

нэгж байгууллагын гадна талбайд мод тарьсан ба иргэд болон байгууллагууд мод тарихдаа гоёлын болон жимсний модыг өөрийн хөрөнгөөр худалдан авч тарих сонирхол илүү давамгайл байдаг байна.

1.2.3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө цөлжилтийг хэрхэн бууруулах, буурах хувь хэмжээг тодорхойлоогүй байгаа тул “Ойн биологийн олон янз байдлын төв” НҮТББ-ын гүйцэтгэсэн “Цөлжилт, газрын доройтлын төлөв байдлыг тогтоох судалгаа, шинжилгээний ажил”-д тулгуурлан цөлжилт буурах хувь хэмжээг аймгийн БОГ-аас боловсруулан гаргах стратеги төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй байна.

1.2.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Баянхонгор аймгийн Ойн салбарын анхдугаар чуулган”-ыг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулагдаж, энэ үеэр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянхонгор аймагт 307 хүн байнгын, 35.0 мянган хүн түр ажлын байраар хангагдах тооцоог тус чуулганаас гаргасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим арга хэмжээний хувьд Ойн газар, гүйцэтгэгч компани хоорондын байгуулсан ГЕН-ийн бусад тавигдах шаардлага хэсэгт “Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай нийт ажилчдын 50 хүртэл хувийг тухайн сум орон нутгийн иргэд, малчдын бүлэг, нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулан хамтран гүйцэтгэх, тухайн орон нутгийн мод үржүүлгийн газраас тарьц, суулгац худалдан авах” гэж тусгаж өгсөн нь сум, орон нутагт түр ажлын байрыг бий болгох давуу талтай байгаа боловч Ойн газраас гүйцэтгэгчийн тайланг аваагүй тул гэрээний тус заалтыг хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар мэдээлэл байхгүй болно.

Аудитын илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд ногоон байгууламж бий болгох, ойжуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ орон нутгийн иргэдээс татан оролцуулах замаар түр болон байнгын ажлын байр бий болгох талаар тусгаагүй байна.

Иймд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд бий болсон түр болон байнгын ажлын байрны тоо мэдээллийг холбогдох сумдын ЗДТГ-аас авч, мэдээний үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн БОГ-т зөвлөв.

1.2.5. Монгол Улсын хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тарьж ургуулах модны арчилгаа, хамгаалалтыг зэрлэг амьтан, малын бэлчээрлэлтээс хамгаалах зорилгоор хашаажуулах, говь цөл, говь хээрийн бүсэд усалгааны эх үүсвэр, усалгааны хэмжээг тодорхойлох, хөв цөөрөм байгуулах, арчилгааны ажлын гүйцэтгэх хүн хүчний тооцоолол зэргийг гаргаж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр тарьц, суулгацыг тарих ажлыг гүйцэтгэхдээ усалгаа, хамгаалалтын асуудлыг хамтад нь шийдэж төлөвлөөгүй бөгөөд сүүлийн жилүүдэд тэдгээр талбайг усалгааны системтэй болгох ажлуудыг зохион байгуулсан байна.

Аудитын явцад сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, мэргэжилтнүүдийг оролцуулан санал асуулга авахад нийт 63 хүн оролцсоноос усалгаа хамгаалалтад зарцуулагдах төсөв дутмаг, ажиллах хүчний хомсдол, гүний худаг, гол горхигүй, усалгааны системгүйн улмаас зөөврийн саваар услах зэрэг хүндрэл бэрхшээл тулгардаг гэж хариулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Улс төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ойжуулалтын арга хэмжээнд сум, орон нутгийн зүгээс оролцох оролцоо хангалтгүйгээс усалгааны асуудлыг шийдвэрлээгүй;

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар модны тарьц, суулгацыг тарих ажлын хүрээнд цөөн сумд усалгааг жилийн хугацаанд хариуцаж, хайс хамгаалалтыг шийдвэрлэсэн байхад ихэнх сумд усалгаа, хамгаалалтыг шийдвэрлээгүй төлөвлөсөн байна.

Шийдвэрлэлт:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ногоон байгууламжийг хүлээн авахдаа түүний арчлалт, хамгаалалтын асуудлыг бүрэн шийдэж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр тарьц суулгацыг тарихдаа тарих талбай, усалгаа хамгаалалтын асуудлыг хамтад нь шийдэж, модыг хүлээн авсны дараах хариуцах албан тушаалтныг тодорхой болгож байх зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.
- Улсын төсвийн хөрөнгөөр ойжуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний усалгаа, хамгаалалтад сум, орон нутгийн зүгээс хамтран ажиллах чиглэлийг хүргүүлж, хяналтыг хэрэгжүүлж ажиллах болон модыг хүлээлгэн өгсний дараах усалгаа, хамгаалалт, хариуцах боловсон хүчний асуудлыг орон нутгийн хэмжээнд тодорхой болгохыг аймгийн БОГ-т зөвлөв.

БҮЛЭГ 2. “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЖ ТАРЬЖ УРГУУЛСАН МОДНЫ УРГАЛТ УСАЛГАА, ХАМГААЛАЛТ, ХАРИУЦАХ ЭЗЭНГҮЙГЭЭС УРГААГҮЙ, УРГАЛТЫН ХУВЬ БАГА БАЙГАА НЬ ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.

2.1. Баянхонгор аймгийн хэмжээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх, ойжуулалтын арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ-ийн дагуу зохион байгуулсан байна.

2.1.1. Баянхонгор аймаг, сумын хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оноос 2025 оны эхний хагас жилийн байдлаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 4,502.1 сая төгрөгийн 35 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс, 1,278.7 сая төгрөгийн 22 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 2,913.9 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 59.5 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар, 250.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг тендер шалгаруулалтын онцгой журмаар худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Дээрх онуудад УТХО-аар 2,276.7 сая төгрөгийн ажил 8 төсөл арга хэмжээ хийхээр төлөвлөснөөс Ойн газраас 799.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээ, ХХААХҮЯ-аас 2023 онд 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээ, 1,227.2 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлэн Баянхонгор аймгийн ЗДТГ болон Баянхонгор аймгийн БОАЖГ худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажилласан байна.

Баянхонгор аймаг, сумын хэмжээнд орон нутгийн төсвөөс нийт 2,225.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл арга хэмжээг төлөвлөснөөс аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 1,801.8 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээ, БХНСАХЗ-аас 394.1 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ, орон нутгийн төсвөөс 29.5 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Орон нутгийн төсвөөс ойжуулалтын арга хэмжээний гүйцэтгэгчийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулахдаа 1,088.7 сая төгрөгийн 20 (74.1%) төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 1,077.2 сая төгрөгийн 5 (18.5%) төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 59.5 сая төгрөгийн 2 (7.4%) төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар тус тус шалгаруулсан байна.

Зохион байгуулсан худалдан авах ажиллагаанаас 174.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл, арга хэмжээний тендерийг 2-3 удаа зарласан боловч оролцогч шалгараагүйгээс амжилтгүй болж, үүнээс 59.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ буюу цөлжилттэй холбоотой судалгаа хийлгэх зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг тухайн үед мөрдөгдөж байсан ТБОНӨХБАҮХАТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.18³-д заасныг үндэслэн шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн, 45.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг Өлзийт суманд эрх шилжүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.

Аймагт эрх шилжин хийгдсэн УТХО болон аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээтэй холбоотой худалдан авах ажиллагааг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас нийцлийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөт аудитаар шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлж, аудитын тайлан, дүгнэлтэд тусгасан болно. Харин Ойн газар, ХХААХҮЯ-д зарласан худалдан авах ажиллагааг аудитад хамруулаагүй болно.

Аудитын явцад сумдаас авсан санал асуулгаар “Мод тарих ажлын гүйцэтгэгчийг хэрхэн сонгон шалгаруулдаг вэ?” гэсэн асуултад 63 албан хаагч хариу ирүүлснээс 55 хувь нь өмнөх жилүүдэд ногоон байгууламжийн ажлыг чанартай гүйцэтгэсэн иргэн, аж ахуйн нэгжийг сонгодог, 34 хувь нь үнэ хямд гүйцэтгэгчийг сонгодог, 8 хувь нь гүйцэтгэгчийг хэрхэн сонгосон талаар мэдээлэл байдаггүй бол 3 хувь нь эрх бүхий албан тушаалтан танилынхаа хүрээнд гэрээ байгуулдаг гэж хариулжээ.

2.1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх ойжуулалтын арга хэмжээтэй холбоотой ажил гүйцэтгүүлэх гэрээнд гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүйд тооцох хариуцлагын талаар тусгайлан заалт оруулаагүй, хариуцлага, хүү, алдангийн хэмжээг тодорхой тусгаж өгөөгүй байна.

Ойн газартай гэрээ байгуулж, УТХО-аар санхүүжүүлж буй ойжуулалтын арга хэмжээтэй холбоотой гэрээнүүдэд захиалагч, гүйцэтгэгч талуудын хүлээх хариуцлага, хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй тохиолдолд тооцох хүү, алдангийн талаар тодорхой тусгаж өгсөн байна. Харин орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх зарим гэрээнүүдэд энэ талаар тусгаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар Баянхонгор аймаг, Баянхонгор сум, аймгийн БОГ, Бууцагаан, Шинэжинст, Баацагаан, Богд, Өлзийт, Эрдэнэцогт, Баян-Овоо сумдын ойжуулалтын арга хэмжээтэй холбоотойгоор гүйцэтгэгчтэй байгуулсан нийт 1,864.0 сая төгрөгийн 72 гэрээг түүвэрлэн үзэхэд 1,459.4 сая төгрөгийн 46 (63.9 хувь) гэрээнд хариуцлага тооцох хүү, алдангийг тусгасан, 376.3 сая төгрөгийн 22 (30.5 хувь) гэрээнд гүйцэтгэгч тал гэрээний үүргээ биелүүлээгүйд тооцох хүү, алдангийн талаар тусгаж өгөөгүй, 28.3 сая төгрөгийн 4 (5.6 хувь) гэрээнд хүү, алдангийн хэмжээг 0 хувиар тусгаж өгсөн байна.

Дээрх зөрчлийн дийлэнх нь төсвийн захирагчтай байгуулсан шууд гэрээнүүдэд гарч байгаа бөгөөд энэ нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд хүлээх хариуцлага, гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлээгүй, ажлыг хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй тохиолдолд тооцох хүү, алдангийн талаар тусгаагүйгээс гэрээний хэрэгжилт, хяналт сулрах, гүйцэтгэгч ажлыг хугацаандаа, чанартай гүйцэтгэхгүй байх нөхцөл байдал үүсэх, улмаар захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд гэрээтэй холбоотой маргаан үүсэхэд шийдвэрлэх хугацаа уртсах, хөрөнгө оруулалтын үр ашиг буурах зэрэг эрсдэлүүд үүсэхээр байгаа тул анхаарч ажиллах шаардлагатай байна.

Орон нутгийн төсвөөр санхүүжих гүйцэтгэгчтэй байгуулсан шууд гэрээнүүдэд дүн шинжилгээ хийхэд зарим гэрээ дугааргүй, санхүүжүүлэх эх үүсвэр тодорхой бус, ажил хүлээлгэн өгөх хугацаа тодорхойгүй, гэрээ байгуулсан болон гэрээн доторх огноо алдаатай,

³ 36.18. Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан зөвлөх сонгох тендер шалгаруулалт хоёр удаа амжилтгүй болсон тохиолдолд шууд гэрээ байгуулж болно. /ТБОНӨХБАҮХАТХ – 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, тухайн үед мөрдөгдөж байсан хуулийн заалт /

утга агуулгын хувьд ойлгомжгүй, гэрээний заалтууд хоорондоо уялдаа холбоогүй, хариуцлагын талаар тусгайлан зааж өгөөгүй, түүвэрт хамрагдсан гэрээнээс 56.8 сая төгрөгийн 3 гэрээнд хийж гүйцэтгэх ажлыг тодорхой заагаагүй зэрэг нийтлэг алдаатай байна.

2.1.3 Аймаг, сумын төсөвт байгууллагуудын захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан ажлын гэрээнд талуудын хүлээх үүргийг тодорхой тусгадаг ч гэрээний үүргээ биелүүлдэггүй, захиалагч ажлын явцад хяналт тавихаар гэрээндээ заадаг ч биелэлт хангалтгүй, хариуцлага тооцдоггүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойжуулалтын арга хэмжээг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд захиалагч байгууллагаас хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, ажлын хэсэг холбогдох асуудалд эргэн хяналт тавиагүй, гүйцэтгэгч шаардлагыг биелүүлсэн гэх боловч аудитын багийн биечлэн хийсэн үзлэг, тооллогоор гүйцэтгэл хангалтгүй байхад хариуцлага тооцоогүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баян-Овоо сумын Засаг дарга “Сумын ногоон байгууламж”-ийн ажил гүйцэтгэх 169.4 сая төгрөгийн гэрээг 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр “Даяндуулим” ХХК-тай байгуулсан ба 2 дахь санхүүжилтийг олгосны дараа Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/74 дугаар захирамжаар “Сумын ногоон байгууламжийн ажлын гүйцэтгэлд явцын хяналт тавих ажлын хэсэг” томилогдож хяналтын хуудас бөглөн гүйцэтгэгч компаниар албажуулж, хяналт хийсэн ажлын талаарх шаардлагатай тэмдэглэл, фото зургийг илтгэх хуудасны хамт тайланд хавсаргахыг үүрэг болгосны дагуу ажлын хэсэг явцын хяналт хийж, акт үйлдэж тайлан бичсэн гэх боловч Баян-Овоо сумын ЗДТГ-ын архивын баримтаас холбогдох нотлох баримт олдоогүй;
- Баянхонгор аймгийн БОГ-ын дарга, “ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэн, Ойн биологийн олон янз байдлын төв НҮТББ”-тай хамтран 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр “Цөлжилт, газрын доройтлын төлөв байдлыг тогтоох судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх” гэрээ байгуулж, гэрээний “4.1.5-д ажлын явцад 3 удаа хөндлөнгийн хяналт хийсэн байх” гэж заасан, 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр “Ойн биологийн олон янз байдлын төв” НҮТББ-тэй байгуулсан “Цөлжилтийн судалгаа хийх зөвлөх үйлчилгээний” гэрээний “4.1.3-т явцын тайланг ирүүлэх, 4.1.4-т ажлын явцад 2 удаа хөндлөнгийн хяналт хийсэн байх” гэж заасныг аймгийн БОГ хэрэгжүүлж ажиллаагүй;
- Богд суманд “Ховд сафари” ХХК-ийн 2023 онд байгуулсан хамгаалалтын ойн зурваст анх тарьсан гэх 2000 ширхэг улиас, 1000 ширхэг хайлаас модны ургалтыг Ойн газраас томилогдсон ажлын хэсэг 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 20х20 хэмжээтэй 5 дээж талбай авч тооллого хийж мод, сөөгийн ургалт 23 хувь гэж дүгнэн, гэрээний ерөнхий нөхцлийн 8.6-д заасны дагуу илэрсэн зөрчил, гологдол арилган 2024 оны 11 дүгээр сарын 15-ны дотор нөхөн тариалалт хийх ажлын шаардлагыг “Ховд сафари” ХХК-д 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүргүүлжээ. Тус аж ахуйн нэгжээс албан бичгийн хариуд 2024 онд нөхөн тарилтаар улиас, хайлаас, бургас тус бүр 1100 ширхэг, нийт 3300 ширхэг модыг тарьснаар тайлагнасан ба Богд сумын засаг даргаас Ойн газрын даргад 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 1а/178 дугаар албан бичигт нөхөн тариалалт хийж, цэнэг усалгааг хийсэн гэсэн албан бичиг хүргүүлсэн байна. Гүйцэтгэлийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр аймгийн БОГ, сумын холбогдох албан хаагчид, аудитын багийн гишүүд тус талбайд 10х10 харьцаатай 5 дээж талбайд ургалтын хувийг “Байгаль орчин ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/93 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралтад заасан Ойжуулалт, ойн ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу тогтооход 34.0 хувьтай байна.
- БОАЖ-ын газрын дарга, “Даяндуулим” ХХК нарын хооронд байгуулсан “Баянхонгор аймгийн Түйн голын сав дагуу ойн зурвас бий болгож мод үржүүлгийн талбай байгуулах” ажлын гэрээ байгуулж, 3 удаагийн шилжүүлгээр санхүүжилтийг гүйцэтгэгчид бүрэн олгосон бөгөөд БОАЖГ-ын даргын 2023 оны А/18 тушаалаар томилогдсон ажлын хэсэг ажлыг хүлээн авахаар очсон боловч ажлын гүйцэтгэл дутуу тул бүрэн хийж, гүйцэтгэсний дараа хүлээн авахаар шийдвэрлэсэн, дахин хяналт тавьсан гэх боловч тайлан байхгүй байна. 2025 оны 09 дүгээр сарын 19-нд аудитын баг тус талбайд шалгалт хийхэд техникийн тодорхойлолтод заасан ажлуудаас газар хагалсан, бэлчээрийн торон хашаа барьсан боловч шон нурсан, тор нь шувтарсан, талбайд 2х2 харьцаатай төмөр гадаргуу бүхий цоожтой модон байшин барьсан зэргээс өөр ажил хийгдээгүй байна.

Захиалагч байгууллага гэрээний биелэлтэд хангалттай хяналт тавиагүйгээс гүйцэтгэгч тал үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй бөгөөд хариуцлага тооцоогүй нь ажил гүйцэтгэлийн чанар, үр дүнд сөргөөр нөлөөлсөн байна.

Иймд цаашид гэрээнд алданги тооцох нөхцөлийг заавал тусгаж, захиалагч тал гэрээний үүргийн биелэлтэд тогтмол хяналт тавьж, гүйцэтгэгч талын биелүүлээгүй гэрээний үүргийг бүрэн биелүүлэх талаар тусгасан зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, бүрэн биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцож ажиллах нь зүйтэй байна.

2.1.4. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ногоон байгууламж, ойжуулалттай холбоотой төсөл арга хэмжээний гэрээнд тарих болон худалдан авах модны нэр төрөл, тоо хэмжээ, нас зэргийг тодорхой заагаагүй байна.

Ойн газрын гүйцэтгэгч талуудтай байгуулсан ойжуулалттай холбоотой ажлын гэрээнд тариалалтын талбайн хэмжээ, модны тоо хэмжээ, нас, төрөл, ажлыг хэрхэн хүлээн авч дүгнэх талаарх холбогдох стандарт, заавар журам, аргачлалын дагуу ургасан модны тооллого, ургалтын хувийг тогтоох арга зүйг тусгайлан зааж, ургалтын хувиас хамаарч ямар арга хэмжээ авч ажиллахыг тодорхой тусгаж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар Баянхонгор аймаг, Баянхонгор сум, аймгийн БОГ, Бууцагаан, Шинэжинст, Баацагаан, Богд, Өлзийт, Эрдэнэцогт, Баян-Овоо сумдын ойжуулалтын арга хэмжээтэй холбоотойгоор гүйцэтгэгчтэй байгуулсан нийт 1,864.0 сая төгрөгийн 72 гэрээг түүвэрлэн үзэхэд 332.9 сая төгрөгийн 15 (20.8 хувь) гэрээнд худалдан авах болон тарих модны нэр төрөл, нас, тоо хэмжээг тодорхой заагаагүй байна.

Захиалагч байгууллагаас гүйцэтгэгчээр мод тариулж, арчлуулж хүлээн авахдаа ургасан модны тооллогыг хэрхэн хийж, ургалтын хувийг тогтоох, хүлээн авсан актад модыг нэр төрөл тус бүрд хамаарах тоо хэмжээгээр нь хүлээн авдаггүй, актыг ерөнхий байдлаар үйлддэг, хүлээн авсны дараах арчилгаа, усалгаа, хамгаалалтыг хэрхэн хийх нь тодорхой бус байгаагаас ойжуулалттай холбоотой ажлын үр дүн сайжрахгүй байна.

Төрийн аудитын газраас 2025 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар сумдын Засаг дарга нарт “...төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлага, төлбөрийн нөхцөл, гүйцэтгэлийн чанар, техникийн тодорхойлолт, чанарын баталгаа, гүйцэтгэх хугацаа, захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, зураг төсвийн үнэ, зураг төсөв зохиогчийн хяналтын зардал зэргийг нарийвчлан тусгаж байх”, “Гүйцэтгэгч аж ахуйн нэгж ажил гүйцэтгэх гэрээнд заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд гэрээний нөхцөлийн дагуу алдангийг тооцож, хариуцлагын механизмыг хэрэгжүүлэх” зөвлөмжийг хүргүүлсэн тул ногоон байгууламж, ойжуулалтын арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэхэд дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

Шийдвэрлэлт: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойжуулалтын арга хэмжээг гүйцэтгэгчтэй байгуулах “Жишиг гэрээ”-г холбогдох хууль, тогтоомжийн дагуу боловсруулж, сум, байгууллагуудад хүргүүлэх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-т хүргүүлэв.

2.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгө оруулалт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

2.2.1. Баянхонгор аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалтын арга хэмжээнд нийт 8,181.6 сая төгрөгийг зарцуулснаас улсын төсвөөс 2,459.2 сая, орон нутгийн төсвөөс 1,534.9 сая, ОНХС-ийн санхүүжилтээс 2,017.8 сая, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 1,223.7 сая, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс 826.6 сая төгрөгийг олгож, бусад орлого, хандиваар 119.5 сая төгрөгийг зарцуулсан байна. (Хавсралт 10)

Баянхонгор аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлснээс төсөл арга хэмжээнд нийт 8,181.6 сая төгрөгийг зарцуулснаас тарьц суулгац худалдан авах болон ойн зурвас байгуулах арга хэмжээнд 4,544.6 сая, хайс хамгаалалт хийх зардалд 903.6 сая, усалгааны систем авах зардалд 689.3 сая, худаг гаргахад 292.2 сая, тээврийн зардалд 61.4 сая, ажиллах хүчний зардалд 886.4 сая, тоног төхөөрөмж худалдан авахад 189.1 сая, сургалтын зардалд 9.9 сая, бусад зардалд 605.1 сая төгрөгийн зарцуулсан байна. (Хавсралт 10)

Ойн газраас санхүүжсэн Богд, Бууцагаан, Шинэжинст, Баянхонгор, Өлзийт сумдад нийт 645.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас 56.0 сая төгрөгийг хамгаалалтын ойн зурвас байгуулахад, 263.0 сая төгрөгийг говийн бүсэд навчит болон бортоготой суулгац, загийн бортоготой суулгацаар ойжуулахад, 326.8 сая төгрөгийг агро ойн аж ахуй байгуулахад олгосон байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойжуулалтын арга хэмжээг гүйцэтгэх гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүд гэрээнд заасан үүргийг бүрэн биелүүлээгүй, ажлыг хүлээлгэн өгөөгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Богд суманд хамгаалалтын ойн зурвас байгуулахаар Ойн газрын 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр байгуулсан 2023/150 дугаартай гэрээнд Богд сумын төвийн хойно авто замын дагуу 5 га талбайг хашихаар заасан бөгөөд аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/618 дугаар захирамжаар томилогдсон аймгийн БОАЖГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг хүлээн авахдаа нийт талбайг 3.5 га талбайд хашаа, хамгаалалт хийсэн гэж тайлагнасан, тус ажлын хэсэг дахин хяналтыг хэрэгжүүлэн 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хяналтыг хэрэгжүүлэн, тус аж ахуйн нэгжид “Талбайн хэмжээг тодорхой болгох, хэрэв техникийн тодорхойлолтод заасан хэмжээнд хүрээгүй бол 5 га-д хүргэх” гэсэн зөвлөмжийг өгсөн боловч зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн тооцоогүй, аудитын багийн хэмжилтээр талбайн хэмжээ 3.5 га байгаа тул Ойн газарт санал хүргүүлэв.
- “Холбоогийн гурван хавцгай ХХК” нь 2022 онд Бууцагаан сумын Овоо түрүүний рашааны эхэд 7000 м2 талбайг 0,5 см-ээс дээш диаметр бүхий гантай цайрдсан утсыг 4*4 см, 6*6 см-н харьцаатай дөрвөлжин эсвэл ромбо нүхтэйгээр сүлжсэн буюу гагнасан төмөр хайсаар, 180 см өндөртэй төмөр бетонон шонгоор 3 хэсэг хашаа барих, модны нүх ухах, 4х2 ажилчдын байр барих, 3 ширхэг худаг гаргах гэрээг байгуулсан бөгөөд тус гэрээний дагуу ажлууд хийгдээгүй байна. Тооллогоор 257 метрийн урттай, 190 метрийн өргөнтэй 4,8 га талбайг модон шон, бэлчээрийн тороор хашиж хамгаалсан байна. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж 200 ширхэг мод тарьсан гэх боловч ургасан мод байхгүй байна.
- Баянхонгор аймгийн БОГ-ын дарга, “Ойн биологийн олон янз байдлын төв” НҮТББ-тэй 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр “Цөлжилт, газрын доройтлын төлөв байдлыг тогтоох судалгаа, шинжилгээний ажлыг 30.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулжээ. Гэрээнд явцын тайланг 2023 оны 08 дугаар сарын эхний 10 хоногт багтаан ирүүлснээр санхүүжилтийн 30 хувийг олгохоор заасан байхад тайлан ирүүлээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, тус ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны дотор хүлээлгэн өгөхөөр байхад хүлээн аваагүй, Баянхонгор аймгийн БОГ нь Баянхонгор аймгийн ИТХ-ын 6 дугаар ээлжит хуралдаанаас гаргасан тус гэрээний ажлын даалгаварт тусгасан ажлыг бүрэн хүлээн авах шийдвэрийг одоо болтол хэрэгжүүлээгүй байна.
- БОАЖГ-ын дарга, “Даяндуулим” ХХК-ийн захиралтай 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр “Баянхонгор аймгийн Түйн голын сав дагуу ойн зурвас бий болгож мод үржүүлгийн талбай байгуулах” гэрээг 44.9 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлыг гэрээнд заасны дагуу ажлыг бүрэн хийгээгүй, хүлээлгэн өгөөгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Шийдвэрлэлт: Гэрээний дагуу үүргээ гүйцэтгээгүй зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах 2 албан шаардлага, 1 зөвлөмжийг аймгийн БОГ-т хүргүүлэв.

Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгийн 169.4 сая төгрөгийн санхүүжилтээр “Сумын ногоон байгууламжийн ажил” гүйцэтгэх 21 тоот гэрээг Баян-Овоо сумын Засаг дарга “Даяндуулим” ХХК-тай 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр байгуулсан, гэрээний хугацаа 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр дууссан байхад гүйцэтгэгч компани ажлаа хүлээлгэн өгөөгүй байна.

Гэрээнд эхний санхүүжилтийн 36 хувь буюу 60.3 сая, дунд үеийн санхүүжилтийн 50 хувь буюу 84.7 сая төгрөгийг ажил гүйцэтгэсэн явцын тайланг ирүүлсний дараа олгох, үлдсэн

санхүүжилтийн 14 хувь буюу 23.7 сая төгрөгийг ажил гүйцэтгэсэн тайлан, хүлээн авсан актаар баталгаажуулж олгохоор заасан атлаа санхүүжилтийн хуваарийг баримтлахгүйгээр санхүүжилтийг гүйцэтгэгч талын нэхэмжилсэн дүнгээр 2022 оны 10 дугаар сард 2 удаагийн, 11 дүгээр сард 1 удаагийн шилжүүлгээр нийт 160.4 сая төгрөгийг олгосон байна.

Гүйцэтгэлийн аудитын баг Баян-Овоо суманд ажиллаж, гүйцэтгэсэн ажлыг газар дээр нь очиж үзэхэд мод тарьсан хамар хооронд усалгааны систем тавигдсан, усалгааны систем нь зарим нь ил, зарим нь элсэнд булагдсан, усан сан байгуулсан ор мөртэй, 2 барилга баригдсан, нуураас талбай доторх усан сан хүртэл PVC хуванцар хоолойгоор ус татах хоолой байрлуулсан, ургасан мод байхгүй, зарим хэсэгт бэлчээрийн торон хайс нь шувтарч унасан нөхцөл байдалтай байна.

Тус гэрээтэй холбоотой асуудлыг Баян-Овоо сумын Засаг дарга 2025 оны 01 сарын 16-ны өдөр аймгийн Прокурорын газарт шилжүүлсэн, одоогоор хариу ирээгүй байна.

Ойн газар Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт Говийн бүсэд навчит модны бортоготой суулгац, загийн бортоготой суулгацаар ойжуулах ОйГ/20240101021 дугаар бүхий ажил гүйцэтгэх 263.0 сая төгрөгийн гэрээг Ойн газраас "Оргил сарьдаг уулс" ХХК-тай 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр 2 жилийн хугацаатай, Богд суманд агро ойн аж ахуй байгуулах Ойг/20250101007-03 дугаар бүхий ажил гүйцэтгэх 217.3 сая төгрөгийн гэрээг "Их хайрханы хаялага" ХХК-тай 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 2 жилийн хугацаатай байгуулсан байна.

Ойн газарт Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас дээрх 2 аж ахуйн нэгжид олгосон шаардлагатай мэдээллийг 2025 оны 09 дүгээр сарын 26-ны дотор ирүүлэхээр 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 1/661 дүгээр албан бичиг хүргүүлсэн боловч санхүүжилтийн мэдээллийг ирүүлээгүйгээс аудитаар дэвшүүлсэн зорилтыг үзэх боломжгүй байв.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас "Ногоон ажлын байр" хөтөлбөрийг 2022 оноос хэрэгжүүлэн, хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор суманд модны нүх ухах, хөрс бэлтгэх, хайс хамгаалалт засаж янзлах, мод тарих, арчилгаа усалгаа хийх, зүлэг цэцгийн мандал тариалах зэрэг ажлуудад иргэдийг хамруулж, түр ажлын байраар ханган цалин урамшуулал олгосон байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь ажилгүй болон орлого багатай иргэдийг улирлын чанартай ажилд өргөнөөр хамруулан, тэднийг мод тарих, арчлах, ногоон байгууламжийн ажлуудад тогтмол оролцуулдаг байна. Тухайлбал, 2022 онд 728 иргэнд 0.6 сая төгрөгийн цалин, 2023 онд 8 сумын хэмжээнд 627 иргэнд 569.8 сая төгрөгийн цалин, 2024 онд 14 сумын хэмжээнд 545 иргэнд 247.8 сая төгрөгийн цалин, 2025 оны хагас жилд 51 иргэнд 25.8 сая төгрөгийн цалин, нийт 2022-2025 онд 3057 хүнийг хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамруулж, 1,393.4 сая төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Төр, хувийн хэвшилтэй хамтарч ажилласан байдал

Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 03 дугаар сарын 14-ний 01 дүгээр тогтоолоор баталсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний дөрөвт Удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн 149-д төр, хувийн хэвшлийн оновчтой түншлэлийг бий болгохоор заажээ.

Дэлхий нийтийг хамарсан экологийн хямрал, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдол бий болж байгаа өнөөгийн цаг хугацаанд ойн салбараа тогтвортой хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн холбогдох байгууллагуудын нягт уялдаа холбоотой ажиллах, санхүүгийн тогтвортой байдлыг бий болгох, байгаль орчны хариуцлагатай бодлогыг болон ойн менежментийг цогцоор нь бий болгож, иргэн хүн бүрийн оролцоог чухалчлан дэмжсэнээр үр хойчдоо эрүүл, ногоон орчин бүрдүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг бий болгох боломжтой байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд төрийн байгууллагаас хувийн хэвшлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч холбогдох зөвшөөрлийг дээд газраасаа аваагүй, гэрээг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулаагүйгээс гэрээний зарим зүйл, заалт тодорхойгүй, гэрээнд ажлын тайлан ирүүлэхийг даалгасан байхад мэргэжлийн байгууллагууд хяналт хийгээгүй, хийсэн хяналтын мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

1. Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн ойн зурваст үйл ажиллагаа явуулж байгаа “Шинэ баян сайр” ХХК

Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн ойн зурваст 100,000 ширхэг үрслэгээний зориулалттай говийн өргөст мод тарих 2022/62 тоот гэрээг аймгийн Засаг дарга "Шинэ баян сайр" ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр 5 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд гэрээнд⁴ 100,000 ширхэг мод суулгацыг суулгаснаас хойш 15-20 см ургасан, ургалтын хувь 80%-аас доошгүй байгаа тохиолдолд 1 ширхэг ургацыг 10,000 төгрөгөөр тооцож нийт хугацаанд 1,0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон байна.

Мөн гэрээний 1.1-т заасны дагуу Шинэ суурьшлын бүсэд 40,000 ширхэг, Өлзийтийн гүүрнээс Өлзийт хүртэлх зам дагуу 60,000 ширхэг үрслэгээний зориулалттай мод тарихаар төлөвлөснөөс Өлзийтийн гүүрнээс Өлзийт хүртэлх зам дагуу 60,000 ширхэг модыг тариагүй, аймгийн ЗДТГ-аас гэрээнд заасан 100,000 ширхэг модыг Шинэ суурьшлын бүсэд тарихаар шийдвэрлэсэн гэх боловч гэрээг шинэчлэн байгуулаагүй байна.

Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн ойн зурваст гүйцэтгэсэн “Шинэ баян сайр” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг Баянхонгор аймгийн Засаг дарга 2023 оны А/493, 2024 оны А/480 дугаар захирамжаар байгуулж, хяналтыг хэрэгжүүлсэн ба аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2024 оны 09 дүгээр сард тооллого хийж, гэрээний 3.3-т заасны дагуу 20 см-ээс дээш ургасан 25,106 ширхэг суулгацыг тоолон, нэг ширхэг ургацыг 10,000 төгрөгөөр тооцож 251.0 сая төгрөгийг дараах байдлаар олгосон байна. Үүнд:

- “Шинэ баян сайр” ХХК-ийн гүйцэтгэж байгаа Шинэ суурьшлын ойн зурваст Баянхонгор сумын Засаг дарга, “Хонгорын эрдэнэс баялаг” ХХК-тай 2023 онд 2 удаа гэрээ байгуулж, Шинэ суурьшлын бүсэд үрээр мод тарих, ногоон байгууламж нэмэгдүүлэхэд 98.3 сая төгрөгийг олгосон байна.
- Шинэ суурьшлын бүсийн ойн зурваст “Шинэ баян сайр” ХХК-ийн гүйцэтгэсэн талбайд аймгийн Засаг даргын 2024 оны А/480 дугаар захирамжийн дагуу тооллого явуулж, гэрээний дагуу 25,106 ширхэг мод ургасан гэж тогтоон, тус аж ахуйн нэгжид өмнөх онд Баянхонгор сумын ЗДТГ-аас олгосон санхүүжилтээс 80.0 сая төгрөгийг суутган тооцож, 171.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/141 дүгээр захирамжаар олгосон байна.

Дээрх санхүүжилт олгосон модод тэмдэглэгээ бүхий пайз зүүгээгүйгээс шалтгаалан ямар төрлийн модыг 10,000 төгрөгөөр худалдаж авсныг аудитаар нотлох боломжгүй мөн хайс хамгаалалт, усалгааны худгийг төсвийн хөрөнгөөр гаргасан байхад санхүүжилтээс хасаж тооцоогүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Ажлын хэсгийн илтгэх хуудсанд 25,106 ширхэг модны нэр төрөл, тоо ширхгийг заагаагүй, ажлын хэсгийн гишүүд туулайн бөөр, харгана байсан гэх тайлбарыг өгсөн бол аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн мэргэжилтэн бүгд туулайн бөөр байсан гэсэн зөрүүтэй мэдээллийг өгсөн.
- Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/141 дүгээр захирамжийн дагуу аймгийн ЗДТГ-аас 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 2/574 дүгээр албан бичгээр чиглэл хүргүүлж, дээрх 25,106 ширхэг модыг орон нутгийн өмчид бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, тарьсан модны арчлалт,

⁴ гэрээний компанийн эрх, үүргийг тодорхойлсон 3.3-т "Тухайн суулгац 100,000 ширхэг мод суулгацыг суулгаснаас хойш 15-20 см ургасан, ургалтын хувь 80%-аас доошгүй байгаа тохиолдолд 1 ширхэг ургацыг 10,000 төгрөгөөр тооцож санхүүжилт төлбөр авна"

хамгаалалтад тогтмол хяналт тавихыг Баянхонгор сумын Засаг даргад үүрэг болгосон байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Гэрээнд ургалтын хувийг аль (үрсэлгээ хийсэн эсвэл шилжүүлэн суулгасан) талбайгаас тооцох тодорхой заалт байхгүйгээс ажлын хэсэг тооллого хийхдээ 2 талбайг нийлүүлэн тоолсон нь Орон нутгийн хувьд ашиггүй байна. Үрсэлгээ хийсэн талбайгаас дараа нь шилжүүлсэн суулгахад хорогдол их, хүсэж буй үр дүнд хүрэхэд хугацаа алдах эрсдэл өндөр байна.
- Хувийн хэвшилтэй хамтран ажиллахдаа өрсөлдөөнийг шударга, ил тод нээлттэй явуулах үүднээс олон нийтэд ил тод мэдээлээгүй, худалдан авах модны өртөг, үнийг тооцоолол судалгаа байхгүй.

Гэрээг байгуулахад мэргэжлийн байгууллагын мэргэжилтнүүд оролцоогүйгээс Өргөст мод (говийн өргөст мод тийм нэршил байхгүй) гэдэгт ямар төрөл нь хамаарахыг заагаагүй ерөнхий нэрээр (тухайлбал: 5м хүртэл ургах чадвартай шар хуайс уу, 1 м хүртэл ургах харгана уу) тусгасан нь тодорхойгүй байдлыг үүсгэж байна.

Тухайн модны усалгаа, арчилгаа сайн байвал өргөст модны төрөл болох шар хуайс болон бутны төрөл болох өргөст харгана жилд 20-30 см хүртэл өндөртэй ургадаг болохыг мэргэжилтнүүд нотолж байна. Гэвч аудитын ажиглалтаар тухайн үрээр тарьсан тарьц нь 3 жил болж байгаа гэхэд ургалт хангалтгүй гэж үзэхээр байна. Тиймээс мод уу, бут уу гэдгээ тодорхойлох зайлшгүй шаардлагатай гэж аудитын баг үзсэн.

Шийдвэрлэлт:

1. Аудитаас үзэхэд шинэ суурьшлын бүсийн ойн зурвасын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй, тарих модны төрөл тодорхойгүй, нэг ширхэг модны өртөг, үнийн тооцоолол хийгээгүй, гэрээний 3 жилийн зорилтод түвшинд хүрээгүй, ургалтын хувийг аль талбайгаас тооцох нь гэрээнд тодорхой бус байгаа нь орон нутгийн төсөвт (100,000 ширхэг мод*10,000 төгрөг) болон хүсэж буй үр дүнд хүрэхэд хугацаа алдах эрсдэлийг дагуулж болзошгүй тул орон нутагт ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэх талаар аймгийн мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан хэлэлцэж, гэрээг дахин нягталж үзэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2. Баянхонгор сумын Засаг даргад зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. “Шинэ суурьшлын бүсийн мод үржүүлгийн газрын ашиглалтыг сайжруулах, хамтран ажиллах” 03/03 дугаартай гэрээ байгуулсан “Их хайрханы хаялга” ХХК

Баянхонгор аймгийн БОГ Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсэд байрлах 127.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Мод үржүүлгийн газрыг түрээслүүлэх зарлалыг олон нийтэд мэдээлж, 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр “Шинэ суурьшлын бүсийн мод үржүүлгийн газрын ашиглалтыг сайжруулах, хамтран ажиллах” 03/03 дугаартай гэрээг санал ирүүлсэн “Их хайрханы хаялага” ХХК-тай байгуулжээ.

Шинэ суурьшлын бүсэд байрлах 2 га талбайг 2027 оныг дуустал 3 жилээр гэрээ байгуулж, тухайн газрыг зориулалтын дагуу ашиглан, нутгийн хөрсөнд дасан зохицсон тарьц, суулгацыг үржүүлэн, туршилт судалгаа явуулах, орон нутгийн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мод үржүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж дадлагажуулж, гэрээний 1.1-т 1.0 саяас доошгүй тарьц, суулгацыг бэлтгэн, гэрээний хугацаанд ургуулан авч, ойжуулалт, ойг нөхөн сэргээх, ногоон байгууламж нэмэгдүүлэхэд орон нутгийг суулгацаар хангахаар гэрээнд заасан байна.

Дээрх түрээсийн гэрээнд “орон нутагт дасан зохицсон 1.0 саяас доошгүй тарьц суулгацыг бэлтгэн гэрээний хугацаанд ургуулан авч ойжуулалт, ойг нөхөн сэргээх, ногоон байгууламж нэмэгдүүлэхэд орон нутгийг суулгацаар ханган нийлүүлэх, түрээсийн төлбөрт 2026 оны намраас эхлэн жил бүр стандартын шаардлага хангасан 25,000 ширхэг суулгацыг тухайн үеийн зах зээлийн ханшаар өгөх” гэж модны тарьц суулгацын нэр төрөл, насыг тодорхой заагаагүй, хүү, алданги, хариуцлагын талаар тусгайлан зааж өгөөгүй байна.

Гэрээний захиалагчийн эрхийн 2.4-т “2026 оны намрын улирлаас эхлэн жил бүр стандартын шаардлага хангасан 25,000 ширхэг суулгацыг тухай үеийн зах зээлийн үнэ ханшаар түрээсийн төлбөрт өгөх”-өөр заасан байна.

Шийдвэрлэлт: “Их хайрханы хаялга” ХХК-тай байгуулсан “Шинэ суурьшлын бүсийн мод үржүүлгийн газрын ашиглалтыг сайжруулах, хамтран ажиллах” гэрээнд тусгасан заалтуудыг аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсээр хянуулах албан шаардлагыг аймгийн БОГ-т хүргүүлэв.

3. Баянхонгор аймгийн ХХААГ-ын жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн плантацийг ажиллуулах гэрээ байгуулсан “Велотрейд” ХХК

Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/679 дугаар тушаалын дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын зүүн талд “Тэнгэрийн уул” ХХК-ийн гүйцэтгэсэн Жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн плантацийн 249.9 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг шилжүүлж, бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусган бүртгэж, зориулалтын дагуу үр дүнтэй ашиглаж, орон нутагт суулгац үйлдвэрлэлийг нэмэгдүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн ХХААГ-т үүрэг болгосон байна.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын эзэмшилд байгаа “Жимсний мод суулгац, үржүүлгийн төвийг “Велотрейд” ХХК-тай хамтран хэвийн үйл ажиллагааг ханган ажиллуулах” гэрээг 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдөр 3 жилийн хугацаатай байгуулжээ.

Аудитын илрүүлэлт:

- Тус талбайд арчилгаа, хамгаалалт хангалтгүйн улмаас 2024 оны өвөл чацарганын модноос 0.4 сая төгрөгийн 130 ширхгийг хулгайд алдсан байна.
- ХХААХҮЯ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 51.5 сая төгрөгийн өртөг бүхий тракторыг аймгийн ХХААГ-ын нэр дээр шилжүүлж бүртгүүлээгүй байна.
- “Велотрейд” ХХК нь аймгийн ХХААГ-тай байгуулсан гэрээний 5.1-д “Жимсний модны ургалт, бойжуулалтын ажлыг тогтмол чанартай хийх, зах зээлд нийлүүлэх суулгацын нэр төрлийг олшруулах, нутагшуулах, тариалалтын мэдээг тогтмол өгч байх, сумдын ногоочдыг сургаж дадлагажуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Гүйцэтгэгч талаас одоогоор хүлэмжид тухайн талбайд тарьсан жимсний модноос үр болон ногоон мөчрөөр үржүүлэг хийж байгаа бөгөөд 2026 оноос ургаж гүйцэж, үр жимсээ өгөхөөр байгаа бөгөөд сумдын ногоочдыг сургаж дадлагажуулах ажлыг хийж гүйцэтгээгүй гэдэг тайлбар ирүүлсэн.
- Аймгийн ХХААГ нь гүйцэтгэгч “Тэнгэрийн уул” ХХК-тай байгуулсан гэрээний 5.8-д Тариалангийн тухай хуулийн 17.2.2 заалтыг хэрэгжүүлэх гэж тусгасан байгаа боловч Тариалангийн тухай хуульд 17.2.2 гэсэн заалт байхгүй байна.
- Жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн төв байгуулах ажил хүлээн авсан актын 2.4-т “Баянхонгор аймгийн ХХААГ нь байгуулсан суулгац үржүүлгийн төвийг зориулалтын дагуу ашиглах, тариалсан суулгацыг арчилж ургуулах, ХХААХҮЯ-аас зөвшөөрөл олгоогүй байхад бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэхгүй байх үүрэг хүлээв” гэж заасан байхад зөвшөөрөлгүйгээр өөр аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж ажилласан байна.
- ХХААХҮЯ-ны “Тэнгэрийн уул” ХХК-тай байгуулсан “Орон нутагт жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн плантаци байгуулах ажил гүйцэтгэх гэрээ” болон Монгол Улсын ХХААХҮЯ-ны сайдын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/679 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтад заасан хөрөнгийн жагсаалтад 4х6 хэмжээтэй агуулахын байр байхгүй байхад аймгийн ХХААГ-ын хүлээн авсан ажлын хэсгийн актад 4х6 хэмжээтэй агуулахын байр 1 ширхэг гэж байгаа боловч аудитын баг газар дээр нь очиж үзэхэд байгаагүй болно.
- ХХААХҮЯ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон жимсний плантацийн 24.8 сая төгрөгийн зөөврийн сууцыг зориулалтын дагуу ашиглаагүй, агуулахын зориулалтаар ашиглаж байгаа тул цаашид хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах нь зүйтэй байна.

Шийдвэрлэлт:

- ХХААХҮЯ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон тракторын гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлж авах албан шаардлага өгөв.
- “Велотрейд” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа талаар ХХААХҮЯ-д мэдэгдэж, чиглэл авч ажиллах, “Велотрейд” ХХК-тай байгуулсан гэрээний зах зээлд нийлүүлэх суулгацын нэр төрлийг олшруулах, нутагшуулах, сумдын ногоочдыг сургаж дадлагажуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг Баянхонгор аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

- Баянхонгор аймагт Жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн төв байгуулах ажил хүлээн авсан ажлын хэсгийн акт, тэмдэглэлийг үнэн зөв болгож, алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх талаар зөвлөв.

4. Тэр бум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих сан, Баянхонгор аймгийн Засаг даргатай гуравласан гэрээ байгуулж, Баянхонгор сумын Огтонотой булагт 2 га талбайд мод бут тарих цэцэрлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж байгаа “Эрдэнэт номгоны хишиг” хоршоо

Тэр бум мод сангаас 2023 онд зарласан төсөл сонгон шалгаруулалтад “Эрдэнэт номгоны хишиг” хоршооны “Хайрын төгөл” төсөл шалгарч Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих сан, Баянхонгор аймгийн Засаг дарга, гүйцэтгэгч “Эрдэнэт номгоны хишиг” хоршоотой 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр 220.8 сая төгрөгийн гуравласан гэрээг 2026 оны 05 дугаар сарын 01-ны өдөр хүртэл хугацаатай байгуулан, төслийн хүрээнд Баянхонгор сумын Огтонотой булагт 2 га талбайд мод бут тарих цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэж байна.

Тус төслийн хүрээнд Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих сангаас нийт 84.4 сая, гүйцэтгэгч “Эрдэнэт номгоны хишиг” хоршооноос 32.0 сая, үлдсэн санхүүжилтийг Тамгын газар хариуцахаар гэрээнд тусгасан байна.(Гэрээнд аймаг, сумын аль ЗДТГ-аас санхүүжүүлэх нь тодорхой бус)

Баянхонгор аймгийн ЗДТГ-аас дээрх төслийг хэрэгжүүлэхэд 20.0 сая төгрөгийн усалгааны худгийг шийдэж, Баянхонгор сумын ЗДТГ-аас ашиглаагүй байсан хайс хамгаалалтыг шилжүүлэн хийж өгсөн байна. Хоршооноос гаргах 32.0 сая төгрөгийн санхүүжилтээр усалгаа, арчилгаа, нөхөн тарилтыг хариуцаж байгаа гэсэн тайлбарыг өгсөн болно.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих сангаас явцын хяналтыг газар дээр нь 2 удаа хийж, гүйцэтгэгч талд холбогдох зөвлөмж, мэдээллийг өгч ажилласан байна.

Аудитын баг тус хоршооны тарьсан модны ургалтын хувийг жишиг талбайн тооллогоор 4 дээж талбай сонгон хийхэд ургалт 85.0 хувьтай, мод тарьсан талбайн захын эгнээний мод, усалгааны систем нь дулааны шугам сүлжээний газар шорооны ажлын нөлөөгөөр шороо чулуунд дарагдсан байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны тоо

Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 03 дугаар сарын 14-ний 01 дүгээр тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө-д тусгасан зорилтын дагуу Баянхонгор аймагт 2030 он хүртэлх хугацаанд нийт 20.0 сая модыг тарихаар хуваарилсан ба Баянхонгор аймгийн БОГ-аас ирүүлсэн мэдээгээр үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш тарихаар хуваарилсан модны 2.59 хувийг буюу 517,725 ширхэг модыг тарьсан гэж тайлагнасан боловч газар зүйн байршлаар нь тулган баталгаажуулалт хийгээгүй байна.

Хүснэгт 6.. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарихаар төлөвлөсөн, тарьсан модны тоо

№	Зорилт	Үйл ажиллагаа	Тарихаар төлөвлөсөн модны тоо	Тарьсан модны тоо
1	Суурин газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нэмэгдүүлэх, ард иргэдийн амьжиргааны нөхцөлийг сайжруулах, “Хотын ой” хөгжүүлэх;	Нийтийн хэрэгцээний	2,030,000	66,367
		Тусгай хэрэгцээний	382,000	114,477
		Хязгаарлагдмал хэрэгцээний	398,675	251,555
2	Цөлжилт газрын доройтол, шороон шуурганы эх үүсвэрийг бууруулах, элсний нүүдлийг сааруулах;	Тариалангийн талбайг хамгаалах ойн зурвас байгуулах	1,157,000	0
		Томоохон голын татмыг нөхөн сэргээх	4,920,500	30,550
		Авто замын хамгаалалтын ойн зурвас байгуулах	392,250	25,126
3		Жимсний аж ахуй байгуулах	1,000,000	2,100

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний зорилттой уялдуулан төрөлжсөн агро-ойн аж ахуй хөгжүүлэх		Агро ойн аж ахуй байгуулах	801,300	0
4	Байгалийн ойг нөхөн сэргээх замаар ойн хомсдол доройтлыг бууруулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх;	Доройтсон ойг нөхөн сэргээх	2,473,250	0
		Заган ойг нөхөн сэргээх	3,227,750	25,850
		Байгалийн сэргэн ургалтад туслах	3,217,275	1,700
		Нийт дүн	20,000,000	517,725

Эх сурвалж: Баянхонгор аймгийн БОГ-ын судалгаа

Аймгийн хэмжээнд тарьсан нийт модны 21.2 хувь буюу 109,874 модыг орчин тойрон болон бичил цэцэрлэг, сад, цэцэрлэгт хүрээлэнд, 27.7 хувь буюу 143,154 модыг хамгаалалтын зурваст, 8.0 хувь буюу 41,554 модыг айл өрхүүд, 25.5 хувийг аж ахуйн нэгж, албан байгууллага, 10.4 хувь буюу 53,779 модыг зориудаар ойжуулсан талбайд тарьж, 7.2 хувийг буюу 37,400 модыг байгалийн сэргэн ургалтад туслах ажлаар хийжээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 оноос 2025 оны эхний хагас жилийн хугацаанд тарьсан 517,725 ширхэг модноос Баянхонгор, Шинэжинст, Өлзийт, Галуут сумд хамгийн олон мод тарьж ургуулсан нь нийт тарьсан модны 55 хувийг эзэлж байна. (Хавсралт 2.)

Аудитын явцад “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг тандах зорилгоор сумдаас авсан санал асуулгаар “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг сумын хэмжээнд та хэрхэн үнэлэх вэ?” гэсэн асуултад 63 албан хаагч хариу ирүүлснээс 40 хувь нь сайн, 50 хувь нь дунд, 10 хувь нь хангалтгүй гэж хариулжээ.

Баянхонгор аймгийн сум дундын ойн анги нь “Ойн баялгийн нөөцийг судлан тогтоож хамгаалах зохистой ашиглах, нөхөн сэргээх үржүүлэх, ойн арга хэмжээ явуулах, тогтвортой менежментийн нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах, бусад шаардлагатай мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх” эрхэм зорилготой байна.

"Тарьц суулгацыг үржүүлж аймаг орон нутагт ханган нийлүүлэх, ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах" эрхэм зорилготой бөгөөд 2024 онд "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд аймаг, орон нутагтаа дасан зохицсон тарьц суулгацаар хангаж, үрийн нөөцөө нэмэгдүүлэх" зорилт тавьж ажилласан байна.

Тус байгууллага нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 дугаар тушаалаар баталсан журмын 3.3⁵-т заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэлт: Цаашид журмын 3.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангид хүргүүлэв.

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь хотын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж, ойжуулалт, хот тохижилт, гудамж талбайн гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн хөшөө дурсгал, нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, хогийн сав байрлуулах, үерийн хамгаалалтын далан, хөрс, усан оргилуур, усан байгууламж ашиглалт, засвар үйлчилгээг хангах чиг үүрэгтэй ажиллаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө-ний 3.2.1-т үр, мөчрийн тайраадасны нөөц бүрдүүлэхэд чанартай үрийн гарал үүслийг онцлон тэмдэглэсэн бөгөөд шинжлэх ухааны үндэслэлтэй байнгын болон түр хугацаанд үр түүж бэлтгэх ойн талбайг тусгаарлаж, бүртгэх, ойн үрийн плантаци байгуулах

⁵ Сум дундын болон сумын ойн анги (цаашид “ойн анги” гэх) нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг зохион байгуулах зорилгоор дор дурдсан үйл ажиллагаа явуулна.

ажлыг эхлүүлэх, зөвхөн гарал үүсэл нь тодорхой үрийг ойжуулалтад ашиглах шаардлагатай гэжээ.

“Түмэн мод” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Сум дундын Ойн ангид 12 нэр төрлийн 606 кг үрийн нөөц ирснээс 2022 онд 77 кг, 2023 онд 141 кг, 2024 онд 154 кг, 2025 онд 60 кг, нийт 432 кг үрийг тарьсан байна.

Баянхонгор аймгийн БОГ-ын гаргасан судалгаагаар Баянхонгор аймагт ойжуулалтын арга хэмжээ, ногоон байгууламжийн үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуйн нэгжид үрээр ургуулсан 39,928 ширхэг, мөчрөөр ургуулсан 303,950 ширхэг тарьц, суулгацын мэдээлэл ирүүлсэн.

Баянхонгор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 7 мод үржүүлгийн газар 2022 оноос 2025 оны эхний хагас жилд үрээр 10,900 мод ургуулж, мөчрөөр 685,730 модыг ургуулжээ.

Баянхонгор аймгийн БОГ-аас ирүүлсэн мэдээ Сум дундын ойн анги болон “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2022–2025 онд үрээр болон мөчрөөр тарьсан мэдээнээс зөрүүтэй байгааг аймгийн БОГ-ын мэргэжилтнээс тодруулахад:

- Сум дундын ойн ангийн мэдээнээс 2022 онд 191,000 мөчрөөр, Сум дундын ойн анги үрээр тарьсан модны тоог дурдаагүй, 2023 онд 20,000 мөчир, 2024 онд 10,000 мөчир, 2025 онд 10,000 улиас, 10,000 бургасаар зөрүүтэй, Сум дундын ойн анги сухай мөчрөөр тарьсан мэдээ оруулаагүй байна.
- Баянхонгор аймгийн БОГ нь 2022 онд “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-аас мод тарих мэдээ аваагүй бөгөөд 2023 оны хувьд 4000 мөчрөөр тарьсан болон үрээр тарьсан модны мэдээ зөрүүтэй байна гэсэн тайлбар ирүүлсэн болно.

Дээрх зөрчил нь Баянхонгор аймгийн БОГ-ын мэргэжилтэн нь албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу Сум дундын ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлийг удирдлага зохицуулалтаар хангах, хяналт тавих чиг үүрэг хүлээсэн байхад удирдлага зохицуулалтаар хангаж, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаар Баянхонгор аймгийн ЗДТГ, БОГ, сумдын ЗДТГ-аас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зарцуулсан хөрөнгө, тарьж ургуулсан модны тоог гаргуулан авахад дараах нийтлэг зөрчилтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ЗДТГ судалгааг гаргаж ирүүлээгүй, аймгийн БОГ-ын мэдээг ирүүлсэн;
- Сумдаас ирүүлсэн судалгааны санхүүжилт, тарихаар төлөвлөсөн модны тоо, гүйцэтгэл нь БОГ-аас ирүүлсэн судалгаанаас зөрсөн;
- Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 12 аж ахуйн нэгжээс 2022 онд 1,052 ширхэг, 2023 онд 10,913 ширхэг, 2024 онд 11,243 ширхэг, 2025 онд 16,171 ширхэг, нийт 39,379 ширхэг модыг тарьсан судалгааг ирүүлсэн боловч аудитын явцад уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийг тулгасан судалгаанд нийт 18 аж ахуйн нэгж 43,379 мод тарьж, 4,000 модоор зөрүүтэй байна.
- Мод тарьсан талбайг зарим сум албан байгууллага, айл өрхийн хашаанд тарьснаар тайлагнасан бол зарим сум хамгаалалтын зурвас, суурин газрын ногоон байгууламжаар тайлагнасан нь нэгтгэх боломжгүй;
- Сумдад ажиллаж байгаа 52 сургагч багшаас 15 нь 2024 оны үйл ажиллагааны тайлан ирүүлсэн, ирүүлсэн тайланд Галуут, Баянлиг сум сургалтад хамрагдсан хүний тоо бичээгүй байна.
- Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын ой, ургамал, цөлжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод “...Сум дундын Ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлийг удирдлага зохицуулалтаар хангах, хяналт тавих” чиг үүргийг заасан байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Баянхонгор аймгийн БОГ-аас сумдаас ирүүлж байгаа судалгаа, тайлан, мэдээний гаргалтад хяналт тавьдаггүй, судалгаа, тайлан, актыг албан бичгээр албажуулан авдаггүй, мэргэжилтнүүдийн ажлын уялдаа холбоо хангалтгүй, Сум дундын Ойн анги, ойн мэргэжлийн

байгууллагуудад хяналт тавьж ажиллаагүй тул энэ талаар аймгийн БОГ, аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-т мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг зөвлөв.

2.2.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бий болсон зарим тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022 оноос 2025 оны эхний хагас жилийн байдлаар аймаг, сумдад 2,061.8 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авснаас дараах хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Сум дундын Ойн анги “Түмэн мод” хөтөлбөрийн хүрээнд олгосон 6х20 харьцаатай 6 ширхэг зуны хүлэмжийг ашиглаагүй, Ойн ангийн 10 га талбайг хүчин чадлаар нь бүрэн ашиглаагүй;
- “Ensure” төслөөс 2024 онд хэрэгжүүлсэн “Баян-Өндөр сумын төвд байрлах мод үржүүлгийн газрын гүний цооногт нарны өлгүүр байрлуулж, иж бүрэн тохижуулах, ус нөөцлөх сав барих” ажлын хүрээнд хийгдсэн 17.3 сая төгрөгийн усалгааны тоног төхөөрөмжийг ашиглаагүй байна.

Шийдвэрлэлт: Төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах албан шаардлагыг аймгийн Сум дундын ойн анги, Баян-Өндөр сумын ЗДТГ-т хүргүүлэв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁶, 16 дугаар зүйлийн 16.5.5⁷, Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 03 дугаар сарын 14-ний 01 дүгээр тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 2.1.28-т заасныг хэрэгжүүлж ажиллаагүйгээс улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөс ойжуулалтын арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн үр ашиг хангалтгүй байна.

2.2.3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, бий болсон ойн зурвас байгуулах, тарьц, суулгац суулгах гэрээний хугацаа дуусахад эзэнгүйдэж, усалгаа, хамгаалалт зогссоноос төсвийн хөрөнгийн үр ашиг буурсан байна. Иймд мод тарихаас өмнө усжуулалтын асуудлыг урьдчилан төлөвлөж, усалгааны асуудлыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд түшиглэн шийдвэрлэх, хашаа, хамгаалалт, хариуцан ажиллах ажиллах хүчнийг бэлдэх нь мод ургахад сайнаар нөлөөлөхөөр байна.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын ой, ургамал, цөлжилт хариуцсан мэргэжилтэн, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, сумдын ЗДТГ-ын албан хаагчидтай хамтран аудитын баг түүврийн аргаар сонгосон сумдад улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг шалгахад дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Шинэжинст сумын Зараа 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт 2022 онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр Шинэжинст сумын Засаг дарга, “Дэлгэр бүрд” ХХК-тай 2 га талбайг хашиж, хайлаас, сухай, бургас, улиас зэрэг модыг тус бүр 310 ширхэг, нийт 1240 ширхэг тарихад 30,0 сая төгрөгөөр санхүүжүүлэх гэрээг 2022 оны 06 дугаар сарын 19-ний өдөр байгуулж, баталгааг 3 жилээр гаргасан ба Шинэжинст сумын Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/74 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэг гэрээнд заасан ажлыг бүрэн хийж, 1200 ширхэг модыг тарьсан гэж дүгнэсэн боловч 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр аудитын баг, аймгийн БОГ-ын мэргэжилтэн, сумын байгаль орчны байцаагч, 2 байгаль хамгаалагч модны тооллого хийхэд тоологдох мод байхгүй байна.
- Бууцагаан сумын Засаг дарга, “Монгол соёл буянт” хоршоотой “Ногоон байгууламж нэмэгдүүлэх, суулгац тарих, хамгаалалт хийх ажлын гэрээ”-г 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр байгуулж, ОНХС-ийн санхүүжилтээр 15.0 сая төгрөгөөр хийхээр гэрээ байгуулж, Буянт голын адагт наадмын талбай хаших, мод тарих ажлыг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүртэл байгуулжээ. Аудитын баг, аймгийн БОГ-ын мэргэжилтэн, сумын ЗДТГ-ын холбогдох албан

⁶ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁷ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

⁸ Баримтлах зарчим: Санхүүжилтийн ил мод, нээлттэй байдлыг ханган, олон талт эх үүсвэрийг бүрдүүлж, хариуцлагатай, хяналттай, үр дүнтэй зарцуулах

хаагчидтай 2025 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр хяналтыг хийхэд 600 ширхэг мод тарьсан гэх боловч 20-40 см өндөртэй 45 ширхэг хайлаас мод тоологдож, модны ургалт 7.5 хувьтай байна.

- Бууцагаан сумын Хамтын цэцэрлэгт хүрээлэнд 2024 онд “Түйн голын төгөл” ХХК нь улсын төсвийн санхүүжилтээр 6 га талбайд 12000 ширхэг 2 төрлийн модны суулгац тарих, 6000 ширхэг улиас модыг тарихдаа 28 эгнээ 3 үе шуудуулан н хэлбэрээр тарьсан гэж ажлын тайланд тусгасан байна. Тооллогоор нэг талаар нь 3 эгнээ, хоёр талаар нь 1 болон 2 эгнээ шуудуулан тарьсан, 2025 онд хавар нөхөн тариалалтыг хийгээгүй байна.

- Бууцагаан сумын Өлзийт 3-р багийн нутаг дэвсгэрт Өлзийт нөмөрт хайрхан хоршоотой байгуулсан гэрээнд агч, хайлаас, улиасны суулгац тарихаар тусгасан боловч тухайн талбайд улиас, агч, бургас, чацаргана зэрэг 4 төрлийн мод ургаж байсан бөгөөд хоршооны дарга нь хайлаас модны оронд бургас тарьсан гэх тайлбар өгсний дагуу 137 ширхэг бургас мод тоологдож нотлох баримт байхгүйгээс бургасыг модны тоонд оруулаагүй. Тарьсан модны ургалт 28 хувьтай байна.

- “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслийн 29.5 сая төгрөгийн санхүүжилтээр 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр аймгийн БОГ 2022 онд цөлжилтийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн дээрх Ойн биологийн олон янз байдлын төв” НҮТББ-тай “Цөлжилтийн судалгаа хийх зөвлөх үйлчилгээний гэрээ” байгуулж, 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр эцсийн тайланг хүлээлгэн өгөхөөр заажээ. “Ойн биологийн олон янз байдлын төв” НҮТББ -аас тус гэрээний дагуу хийсэн ажлын танилцуулгыг аймгийн ИТХ-ын ээлжит 6 дугаар хуралдаанд танилцуулан, аймгийн ИТХ-аас “Сум бүрд холбогдох тайланг хүргүүлж, “Ensure” төслийн хүрээнд хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулах” талаар аймгийн Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид үүрэг болгосон байхад одоог болтол хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэлт: Шинэжинст, Бууцагаан сумдын Засаг дарга, аймгийн БОГ-т зөрчлийг арилгах хугацаатай 5 албан шаардлага хүргүүлэв.

Ойн газар “Говь-Алтай, Баянхонгор аймгуудад доройтсон ой, говь хээрийн бүс, хамгаалалтын зурвас байгуулах, голын татмын ойжуулалтын зураглал гаргах” Ойг/20250201022 дугаар гэрээг “Байгаль орчин тогтвортой хөгжлийн санаачилга” ТББ-тай 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр байгуулж, тус ажлыг 150.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэн, эцсийн тайлангийн төслийг 2025 оны 11 дүгээр сарын 05-ны дотор ирүүлж, эцсийн тайланг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны дотор хэлэлцүүлэн хүлээлгэн өгөхөөр заажээ.

Тус ажлын зураглал гаргах ажлын даалгаварт мод тарих талбай сонгох ажлыг “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны зорилт болгоноор буюу Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Галуут, Өлзийт, Жаргалант сум тус бүр дээр доройтсон ойг нөхөн сэргээх, сум бүрд хамгаалалтын ойн зурвас байгуулах, говь хээрийн бүсийн ойжуулалт, татмын ойжуулалт, агро ой аж ахуй байгуулах, зураглал гарган боловсруулах ажлыг гүйцэтгэн, сонгогдсон талбай тус бүрээр тарих модны төрөл зүйл, тоо хэмжээ, эдийн засгийн тооцоолол гаргах, талбай тус бүр дээр дүгнэлт гаргах, зураглал хийгдсэний дараа талбай тус бүрийн аймаг, сумдын ИТХ-аар батлуулахаар байна.

Иймд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн, “Байгаль орчин тогтвортой хөгжлийн санаачилга” ТББ-ийн гаргасан дээрх зураглалын дүгнэлтийн дагуу байгаль орчны доройтол, цөлжилт, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Ойн газрын 2024 оны 01/726 дугаар албан бичгээр ирүүлсэн “Бүх нийтээр мод тарих өдөр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, арчлах үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хавсралтын 7-д “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог хангаж, мод тарих талбай, тарьц суулгацыг бэлтгэх, тарьсан модыг жилийн турш услах, арчлах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах” гэсэн арга хэмжээг тусгасан ба хэрэгжилтийг тайлагнахдаа усалгаа арчилгааны талаар ямар арга хэмжээ авсныг тусгаагүй нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр тарьсан модны ургалт хангалтгүй байхад нөлөөлөх хүчин зүйл болсон гэж үзэхээр байна.

Мөн суулгацын нүхийг бэлтгэх, суулгах Ерөнхий шаардлагын 5.5⁹, 5.6¹⁰-т заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, ой, ойн зурвас байгуулах ажлууд 1-3 жилийн хугацаатай хийгдэж, хугацаа нь дуусахад эзэнгүйдэж хамгаалалт, арчилгаа зогсож байгаа, орон нутгаас тогтвор суурьшилтай ажиллах мэргэжлийн боловсон хүчин хариуцаж ажиллахгүй байгаа зэрэг нь модны ургалтад сөргөөр нөлөөлж байна. Иймд аймаг, сумын орон нутгийн удирдлагын урт хугацааны менежмент, тогтвортой алсыг харсан бодлого, хариуцлагын асуудлыг шат шатандаа анхаарах нь зүйтэй байна.

Төсвөөс санхүүжүүлж байгаа төсөл арга хэмжээний хувьд орон нутгаас тогтвортой ажиллуулах, хариуцлагатай ажиллах хүчнийг бэлтгэх, тарьц, суулгацыг холбогдох стандартуудын дагуу тарьсан нийцсэн эсэхийг хүлээн авсан комиссын актад тусгах талаар гэрээнд нэмэлтээр оруулах нь зүйтэй байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 дүгээр тушаалаар баталсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журам¹¹-ын 3.2.5¹¹ гэснийг Баянхонгор аймгийн хэмжээнд бий болсон ойжуулалтын арга хэмжээнд аймгийн БОГ нь хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэлт: Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ойжуулалтын арга хэмжээний санхүүжилтийг олгох, хүлээн авахдаа “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журам¹¹-ыг баримталж ажиллаж талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгч, хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн БОГ-т хүргүүлэв.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ойжуулалтын арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байгаа нь журмын 4.5¹², 4.7¹³-д заасан зарчмыг баримталж санхүүжилтийг олгоогүй, журмын 4.9¹⁴-д заасан 2-7 дугаар хавсралтаар баталсан актуудыг үйлдээгүй зэрэгтэй холбоотой байна.

Шийдвэрлэлт: Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 дүгээр тушаалаар баталсан журмын 4.5, 4.9-д заасны дагуу санхүүжилтийг олгож, ажлыг хүлээн авч байх зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

2.2.4. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд өөрийн хөрөнгөөр тарьц, суулгац ургуулах ажлыг гүйцэтгэсэн 47 иргэнд 2022-2024 онд төсвөөс 7.2 сая төгрөгийн урамшууллыг олгожээ.

Ойн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4¹⁵, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2015 оны А-140/63 дугаар тушаалаар баталсан “Ойг хамгаалах, тарьц, суулгац ургуулах ажлыг урамшуулах журам”-ын 3.3¹⁶-т заасны дагуу 2022 онд Заг сумын ЗДТГ 3.0 сая, 2023 онд Баянхонгор сумын ЗДТГ 1.9 сая, 2024 онд Жаргалант сумын ЗДТГ 0.3 сая, Ойн газраас 2.1 сая төгрөгийг олгожээ. (Хавсралт 11)

⁹ Мод тарьсан тогооны хана 5-10 см өндөртэй, 1 модыг 60-80 литр усаар усална.

¹⁰ Мод услах тогоог эхний 3 жил тогтмол цэвэрлэж, зэрлэг ургамлыг устгаж, хөрсийг сийрүүлж байвал зохино.

¹¹ Аймгийн БОГ нь ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлийг хүлээн авахдаа нарийвчилсан жишиг талбайн тооллого явуулж хүлээн авах

¹² Ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг гэрээний дагуу санхүүжүүлэхэд дараах зарчмыг баримтална...бичих

¹³ Ойжуулалт, ойн зурвас төгөл байгуулах, ойг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэсэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойжуулсан талбайгаа 3 жилийн хугацаанд арчлан хамгаалж ургуулах бөгөөд энэ үзүүлэлтийг дараагийн ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад нэг шалгуур үзүүлэлт болно.

¹⁴ Ойжуулалтын ажлын гүйцэтгэлийг энэхүү журмаар баталсан тушаалын 2-7 дугаар хавсралтын дагуу актаар хүлээн авна

¹⁵ Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг зохих журмын дагуу төрөөс худалдан авах буюу бусад хэлбэрээр урамшуулна.

¹⁶ Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь мод үржүүлгийн газарт өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, тарьж ургуулсан чанартай тарьц, суулгацад төрөөс мөнгөн болон бусад хэлбэрээр урамшуулал олгоно.

Хүснэгт 7. Тарьц, суулгац ургуулсан иргэдэд олгосон ажлын урамшуулал (сая.төг)

№	Он	Сумын нэр	Өрхийн тоо	Тарьсан мод	Мөнгөн дүн
1	2022	Заг сумын ЗДТГ	6	Чацаргана	3.0
2	2023	Баянхонгор сумын ЗДТГ	30	Чацаргана, монос, өрөл, агч, нарс, улиас, хайлаас, үхрийн нүд, алим, чавга, бургас, гацуур, хус,	1.9
3	2024	Ойн газар	5	Хайлаас, үхрийн нүд, голт бор, алимын мод, чацаргана, улиас, шар хуайс, буйлс, бургас, монос, нохойн хошуу, гүйлс, өрөл, агч, алим, чавга, бэсрэг алим, цагаан бургас	2.1
4		Жаргалант сумын ЗДТГ	6	Чацаргана, үхрийн нүд, улиас, хайлаас, шар хуайс, бургас	0.3
ДҮН			47		7.2

Эх сурвалж: Байгууллагуудаас ирүүлсэн судалгаа

Аудитын явцад авсан судалгаагаар Шинэжинст сумын 4 иргэнд 2024 онд “Эрдэнэ Монгол” ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ 24.9 сая төгрөгийг олгосон байна.

Байгаль орчин, нөхөн сэргээлтийн талаар мэдлэг олгох нэг хэлбэр бол нутгийн иргэдийг мод тарих, цэцэрлэгжүүлэх ажилд татан оролцуулах нь чухал бөгөөд хүн бүр, айл өрх бүр, байгууллага, аж ахуйн нэгж бүр мод тарьж ургуулдаг, байгалиа бүтээдэг, байгалиа хамгаалахын төлөө нэгддэг байх нь зүйтэй тул олон нийтийг ойжуулалтын арга хэмжээнд уриалах, тэднийг урамшуулах бодлогыг боловсруулах шаардлагатай байна.

Цахим орчноос судлахад цөлжилттэй тэмцэх, ойжуулалтын ажлын үр дүнг дээшлүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 2007 онд “Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам” баталсан, Хөвсгөл аймгийн ИТХ 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 35 дугаар тогтоолоор “Мөрөн сумын хэмжээнд хашаандаа мод тарьсан өрхийг урамшуулах журам”-ыг 2026-2028 онд хэрэгжүүлэхээр баталсан гэсэн мэдээллүүд байгаа бөгөөд аймгийн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнээс энэ талаар тодруулахад Баянхонгор аймгийн хэмжээнд тус асуудал хөндөгдөөгүй байна.

Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 03 дугаар сарын 14-ний 01 дүгээр тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 3.2.4-т заасан 2021-2024 онд иргэдэд дараах дэмжлэгийг үзүүлэхээр заасан боловч аймгийн хэмжээнд арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүй байна.



Иргэдийг эдийн засгийн ач холбогдолтой жимс, жимсгэнийн тарьц, суулгацыг тарих, хэрэгцээнээсээ илүү гарсан мод, сөөгийг зах зээлд нийлүүлэх боломж нөхцөлөөр дэмжлэг үзүүлэх нь зүйтэй байна.

Шийдвэрлэлт: Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1¹⁷, 31.2¹⁸ дахь заалтуудыг хэрэгжүүлэн, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг идэвхжүүлэх, цөлжилтийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, байгальд ээлтэй, зөв хандлагыг төлөвшүүлэх зорилгоор бусад аймагт үр дүнтэй хэрэгжиж байгаа хашаандаа өөрийн хөрөнгөөр мод тарьц ургуулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах, Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгасны дагуу иргэдэд дэмжлэг үзүүлэх бодлогыг орон нутгийн хэмжээнд судалж шийдвэрлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.2.5. Ургалтын хувь тогтоох ажилд бүх сумдыг бүрэн хамруулаагүйгээс “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд гаргасан тайлан, мэдээллийн үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлжээ.

Баянхонгор аймгийн БОГ-ын дарга 2023 оны 389, 2024 оны 349 дүгээр албан бичгийг сумдад хүргүүлж, өмнөх жилүүдэд тарьсан модны тооллого ургалтын хувийг тогтоох ажлыг зохион байгуулжээ.

Ойн газрын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/726 дугаар албан бичгээр “Бүх нийтээр мод тарих өдөр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, арчлах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г ирүүлж, 11 арга хэмжээг хэрэгжүүлэхийг аймгийн БОГ-т даалгасан байна.

Тус төлөвлөгөөний 3-т заасны дагуу 2021 оны намрын улирлаас эхлэн таригдсан модны амьдралтын хувийг тогтоох тооллого хийж ирүүлэх арга хэмжээний дагуу Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2024 онд 422,412 ширхэг модыг тарьснаас 2024 оны намрын мод тооллогоор 271,747 ширхэг мод ургаж 61.9 хувьтай гэж тайлагнажээ.

Аудитын явцад мод, сөөгийн тооллогыг хэрхэн яаж хийдэг талаар сумдаас авсан санал асуулгаар 18 хувь нь жишиг талбайн тооллогоор талбай сонгож тоолдог, 63 хувь нь нэг бүрчлэн тоолдог бол 19 хувь нь модны тооллогод оролцож байгаагүй гэж хариу ирүүлсэн байна. Иймд аймгийн БОГ-аас сумдад тооллого хийх талаар арга зүйн зөвлөмжийг хүргүүлж ажиллахыг зөвлөв.

Ургаагүй модны шалтгааныг мал амьтан идсэн, технологи хангаагүй, өвчин хортноос, цаг уурын онцгой шалтгаанаар гэсэн ангиллаар гаргахаар байхад сумдын холбогдох албан тушаалтнууд маягтыг бүрэн бөглөж ирүүлээгүйгээс дээрх онуудад тариад ургаагүй 150,665 ширхэг модны шалтгааныг нэгтгэх боломжгүй байна.

Сумдын ЗДТГ-аас Баянхонгор аймгийн БОГ-т ирүүлсэн 2021-2024 онд тарьсан модны ургалтын хувийг тогтоосон акттай танилцахад дараах нийтлэг зөрчилтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн БОГ нь Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2024 онд тарьсан модны ургалтын дундаж хувийг 61.9 хувьтай гэж Ойн газарт тайлагнасан байхад Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн архивын баримтад хавсаргасан судалгаагаар 64.3 хувьтай тайлагнасан;
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2024 онд тарьсан модны ургалтыг тогтоосон актыг Баацагаан, Бууцагаан сум ирүүлээгүй;
- Эрдэнэцогт, Жаргалант сумдын тооллогын акт аймгийн БОГ-ын архивын баримтад байхгүй;
- Мод тарьсан талбайг зарим сум албан байгууллага, айл өрхийн хашаанд тарьснаар тайлагнасан бол зарим сум хамгаалалтын зурвас, суурин газрын ногоон байгууламжаар тайлагнасан нь нэгтгэх боломжгүй;
- Ихэнх сум хорогдсон модны тоог журамд заасны дагуу мал амьтан идсэн, технологи хангаагүй, өвчин хортон, цаг уурын шалтгаалсан зэргээс аль нь болохыг ангилаагүй;
- Хорогдсон модны шалтгаанд усалгаа дутагдсан, хамгаалалт, хариуцах эзэн байхгүй гэсэн тайлбар хэсэг байхгүйгээс мэдээлэл үнэн зөв гарах байдал дутагдалтай
- Баянцагаан сумын тооллогод ургаж байгаа модны тоо нь анх тарьсан модны тооноос их;

17 Аймаг, нийслэлийн Засаг дарга бүх нийтээр мод тарих сарын ажлыг жил бүр зохион байгуулж, 16 насанд хүрсэн иргэн бүр нэг, аж ахуйн нэгж, байгууллага таваас доошгүй мод тарьж ургуулах, услах, арчлах бөгөөд өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд зардлыг хандивлана.

18 Сум, баг, дүүрэг, хорооны Засаг дарга мод суулгах талбайг сонгох, хөрс боловсруулах, тарьц суулгацаар хангах, тэдгээрийг услах, арчлах ажлыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, уг ажилд иргэдийг татан оролцуулна.

- Өлзийт сум он тус бүрээр байршлаар нь модны тооллогыг ирүүлээгүй, оноор нь нэгтгэж гаргасан байна.

Дээрхээс харахад аймгийн БОГ актыг хэрхэн гаргах талаар арга зүйн зөвлөгөө, чиглэл өгөөгүйгээс сумдын ЗДТГ-аас өөр өөр загвараар гаргаж ирүүлсэн, тоон мэдээллийн чанар, үнэн зөв байдал хангалтгүй байгаа нь аймгийн хэмжээний мэдээллийг үнэн зөв, бүрэн нэгтгэхэд эрсдэлтэй байна.

Шийдвэрлэлт: Модны ургалтын хувийг бүх сумдад зохион байгуулж, сум, байгууллагаас ирүүлж байгаа мэдээний үнэн зөв байдал тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж байх зөвлөмжийг аймгийн БОГ-ын даргад хүргүүлэв.

Ойн газрын 2024 оны 01/726 дугаар албан бичгээр ирүүлсэн “Бүх нийтээр мод тарих өдөр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, арчлах үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хавсралтын 2-д “.... тарьц, суулгацын гарал үүсэлд хяналт тавьж ажиллах” арга хэмжээг хэрэгжүүлэхээр зааж, хэрэгжилтийн тайланд “...тарьц суулгацын стандартад сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хяналт тавьж ажилласан” гэж тайлагнасан хэдий ч гарал үүслийн гэрчилгээг аваагүй, хяналт хийсэн талаар нотлох баримт байхгүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа ойжуулалтын арга хэмжээний тарьц, суулгацын гарал үүслийн гэрчилгээг авч байгаад хяналт тавьж ажиллах, хяналт тавьсан талаарх нотлох баримтыг сумдын албан тушаалтнуудаас авч байхыг аймгийн БОГ-т зөвлөв.

2.2.6. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжиж эхэлснээс хойш цөлжилт буурсан эсэхийг дүгнэх хугацаа болоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1¹⁹, 11.2²⁰ дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 333 дугаар тогтоолоор баталсан журмыг үндэслэн Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 03 дугаар сарын 14-ний 01 дүгээр тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд Цөлжилт газрын доройтол, шороон шуурганы эх үүсвэрийг бууруулах, элсний нүүдлийг сааруулах” зорилт хамаарч байгаа бөгөөд тус төлөвлөгөөнд Говь-сүмбэр, Дорноговь, Дундговь, Төв, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгийн нийт нутаг дэвсгэрийн 50-95 хүртэл цөлжилт, газрын доройтолд өртсөн байна гэж тэмдэглэжээ.

Монгол орны 2020 оны цөлжилтийн үнэлгээний атлас дахь Баянхонгор аймгийн цөлжилтийн төлөв байдлын зурагт аймгийн нийт нутгийн 82 хувь буюу 6.2 хувь нь нэн хүчтэй, 4.8 хувь нь хүчтэй, 30.8 хувь нь дунд, 41.1 хувь нь сул зэрэглэлд өртсөн гэж тогтоосон байна.

Баянхонгор аймгийн цөлжилтийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн Шинжлэх ухааны академийн Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн суурь судалгааны эцсийн тайланд цөлжилтийн төлөв байдлыг дээрхтэй адил тодорхойлсон ба “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилт, доройтол буурсан үзүүлэлт 5-10 жилийн дараа мэргэжлийн байгууллагаар тогтоолгоно” гэсэн тайлбарыг аймгийн БОГ-аас албан бичгээр ирүүлсэн болно..

¹⁹ Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаарх Засгийн газрын бүрэн эрх: Байгаль, орчныг хамгаалах эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж, энэ хүрэн дэх Засгийн газрын болон Засгийн газрын бус /олон нийтийн/ байгууллагын үйл ажиллагааг зохицуулна.

²⁰ Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаарх Засгийн газрын бүрэн эрх: Байгалийн баялгийг судалж нөөцийн хэмжээ, эдийн засгийн нэгдсэн үнэлгээг тогтоох, хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчны тэнцвэрт байдал болон үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжлийн шүтэлцээг хангах нэгдсэн арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.

2.3. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2024 онд Засгийн газрын урт хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгах хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг сум бүрээр үнэлээгүй, жил бүрийн гаргасан үнэлгээг олон нийтэд ил тод мэдээлж ажиллаагүй байна.

2.3.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд иргэдийн хамрагдалт хангалтгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралтын 37-д Мод тарих, арчлах, ургуулах чиглэлээр 1000-аас доошгүй сургагч багш бэлтгэж, орон даяар сургалт зохион байгуулах, зорилтот хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх арга хэмжээг Боловсрол шинжлэх ухааны яамд даалгаж, хамтран гүйцэтгэгчээр Байгаль орчин аялал жуулчлалын яам, аймаг, нийслэлийн ЗДТГ-т даалгаж, уг шийдвэрийн дагуу иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог хангаж, мод тарих талбай, тарьц суулгацыг бэлтгэх, тарьсан модыг жилийн турш услах, арчлахад зөвлөгөө, мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий сурагч багш бэлтгэх ажлыг 2022 оноос эхлэн аймаг, сумдад зохион байгуулсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ойн бодлого зохицуулалтын газар, Монгол Улсын Их Сургууль, “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төсөл”-ийн багтай Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран 2022 онд “Мод тарих 1000 сургагч багш”-ийн хүрээнд хээрийн сургалт зохион байгуулснаар Баянхонгор аймаг, сумдын хэмжээнд 20 сумын 52 сургагч багш байгаагаас 20 нь байгаль хамгаалагч, 18 нь байгаль орчин, хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй мэргэжилтэн, 9 нь иргэн, 4 нь байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөл, хоршоо, төрийн бус байгууллагын гишүүн, 1 нь ерөнхий боловсролын сургуулийн багш байгаа ба 2024 оноос сургагч багшийн үйл ажиллагааг эхэлсэн, 52 сургагч багшаас 15 нь 2024, 2025 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангаа аймгийн БОГ-т ирүүлсэн ба тайланд тусгаснаар давхардсан тоогоор

✓ 2024 онд 5,727 сурагч, албан хаагч, иргэнийг

✓ 2025 онд 7,575 сурагч, албан хаагч, иргэнийг мод тарих, арчлах, ургуулахтай

холбоотой зөвлөгөө мэдээллээр хангаж, үйл ажиллагаанд татан оролцуулсан байгаа нь өмнөх оноос 32 хувиар өссөн байна. (Хавсралт 3)

Нийт сургалтад хамрагдагчдын тоог Баянхонгор аймгийн 2024 оны жилийн эцсийн хүн амын тоо²¹-той харьцуулахад хүн амын 15 хувь нь сургалтад хамрагдсан байгаа тул сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Сумдаас ирүүлсэн тайлангаас харахад цахим хуудсаар сурталчилсан контентын тоо 19,257 хүнд хүрсэн байгаа нь цахим сүлжээг ашиглан иргэд, олон нийтэд мэдээлэл түгээх нь илүү олон хүнд хүртээмжтэйг харуулж байгаа тул цаашид сурагч багш нарын үйл ажиллагааг идэвхжүүлэх, тайлан мэдээг тогтмол авч байхад анхаарах, мод тарьж, ургуулах, арчлах чиглэлээр цахим мэдээллийн эх үүсвэрийг ашиглан мэдээлэл түгээх зэрэгт анхаарах нь чухал байна.

Иймд аймгийн хэмжээнд сургагч багшийн тоог нэмэгдүүлж, экологийн боловсролыг бүх түвшинд түгээх, иргэдийн мод тарих соёлыг төлөвшүүлэх, олон нийтэд мод тарих, ургуулах, арчлах талаар сургалт нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах, сургалтад хамрагдагчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн БОГ-т зөвлөв.

²¹ Монгол Улсын хүн ам гэж МУ-ын нутаг дэвсгэрт байнга (183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар) оршин суугаа МУ-ын харьяат иргэд болон гадаадад амьдарч байгаа МУ-ын харьяат иргэдийг хэлнэ. Баянхонгор аймгийн 2024 оны хүн амын тоо 88,029. 1212.mn

2.3.2. Сумдын ЗДТГ-аас тарьсан модны тоог үнэн зөв мэдээлж байгаа эсэхэд тавих хяналт хангалтгүй аймгийн БОГ, сумдын ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс тайлагнасан аймгийн хэмжээнд тарьсан модны тоо зөрүүтэй байна.

Аудитаар 2022-2024 он, 2025 оны эхний хагас жилийн хугацаанд Баянхонгор аймгийн хэмжээнд тарьж, ургуулсан модны тоог сумдаас, БОГ-аас нийт сумдын нэгтгэлээр болон аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн жил бүр үнэлдэг аймаг, сумдын Засаг даргын гэрээнд заасан үзүүлэлтээр харьцуулахад дараах зөрүү гарсан болно. Үүнд:

- Сумдаас ирүүлсэн тайлант хугацаанд тарьсан модны судалгааг аймгийн БОГ-аас ирүүлсэн судалгаатай тулгахад 20,174 ширхэг модоор зөрүүтэй байна. Үүнээс Шинэжинст, Бууцагаан, Галуут, Жинст, Баянхонгор, Баянговь сумд 500 ширхгээс дээш тоогоор модыг зөрүүтэй мэдээлсэн нь сумаас нөхөн тариалалт хийсэн модны тоог БОГ-т хүргүүлсэн судалгаанд шинээр тарьсан модны тоонд оруулж мэдээлсэн байхад БОГ нь нөхөн тарилтын мэдээлээгүй (Хавсралт 4);
- Сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлын санхүүжилтийн мөнгөн дүнг сумдын санхүүгийн ажилтнуудаас аваагүйгээс зөрүүтэй мэдээлсэн;
- Сумдын мэргэжилтнүүд мэдээ, тайланг БОГ-т албан бичгээр баталгаажуулан ирүүлдэггүй;
- Аймгийн БОГ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн болон хувийн хэвшил, иргэдээс тарьц, суулгацын үнийн судалгааг авч, байгууллагуудад жил бүр хүргүүлдэг боловч сумдын болон орон нутгийн байгууллагууд тарьц суулгацыг хаанаас, ямар үнээр худалдан авч байгаа, тарьц, суулгацыг худалдан авахад ямар хүчин зүйл нөлөөлж байгаа талаар мэдээлэл солилцож, дүн шинжилгээ хийж ажиллаагүй байна.

Дээрх байдлаас харахад төрийн байгууллагуудын албан хаагчдын уялдаа холбоо сул, хариуцлагагүй байдлаас шалтгаалан мэдээ тайлан буруу нэгтгэгдэх, цаашид санхүүгийн болон хөтөлбөрийн урт хугацааны зорилтод сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул хариуцсан албан тушаалтнуудын уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн үнэн зөв байдлыг хангаж ажиллах нь зүйтэй байна.

Ойжуулалтын арга хэмжээний хүрээнд 2022 оноос 2025 оны эхний хагас жилд тарьсан модны тоог сумдын ЗДТГ-ууд аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т ирүүлэхдээ аймгийн БОГ-т мэдээлсэн тооноос зөрүүтэй тайлагнажээ.

Хүснэгт 8. 2022-2025 онд тарьсан модны тоо мэдээ

Он	Аудитын хүрээнд сумдаас авсан судалгаагаар	БОГ-аас ирүүлсэн судалгаагаар	ХШҮХ-т хүргүүлсэн засаг даргын гэрээний биелэлтээр
2022 он	184,228	211,808	139,186
2023 он	128,112	118,432	146,356
2024 он	145,638	147,148	103,087
2025 оны хагас жил	39,573	40,337	6,650
Нийт	497,551	517,725	395,279

Эх сурвалж: Аудитаар авсан судалгаа, ХШҮХ-ийн үнэлгээний тайлан

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ нь аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний мод тарих арга хэмжээний хэрэгжилтийг тооцохдоо аймгийн БОГ-ын мэдээтэй тулгаж, ирүүлсэн мэдээ үндэслэлтэй эсэхэд дүн шинжилгээ хийж ажиллаагүй байна.

Дээрх зөрчил нь Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн

захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх журам”-ын 3.1.7²², 4.9.4²³-т нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгасан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг сум бүрээр үнэлэхдээ аймгийн БОГ-т ирүүлсэн тайлангийн тоон мэдээлэлтэй тулгаж үнэлгээ хийж байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-т хүргүүлэв.

2.3.3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг олон нийтийн цахим хуудсаар мэдээлдэг боловч хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс Баянхонгор аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах заалтуудыг холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу жил бүр үнэлсэн байна. Үүнд:

- ✓ 2022 онд сумдын Засаг даргатай байгуулсан 2022/01-2022/20 дугаартай гэрээний 78-т “Тэрбум мод тарих ажлын хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх”
- ✓ 2023 онд сумдын Засаг даргатай байгуулсан 2023/01-2023/20 дугаартай гэрээний 111-т “Тэрбум мод тарих ажлын хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх”
- ✓ 2024 онд сумдын Засаг даргатай байгуулсан 2024/01-2024/20 дугаартай гэрээний зургаадугаар хавсралтад заасан хүрэх түвшнээр
- ✓ 2025 онд сумдын Засаг даргатай байгуулсан 2025/01-2025/20 дугаартай гэрээний 16.16-т заасан “Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд хамгаалалтын ойн зурвас байгуулах, мод тарих боломжит газрын судалгааг гарган 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулах” гэсэн заалтуудыг гэрээнд тусгасан.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 5.5-т заасан “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх арга зүй”-н дагуу Засаг даргын гэрээнд заасан мод тарьж ургуулахтай холбоотой заалтын дагуу ХШҮХ-ээс үнэлсэн үнэлгээг аудитаар нэгтгэхэд Баянговь, Баян-Овоо, Баянцагаан сумдын хэрэгжилт 100 хувь үнэлсэн бол Бууцагаан, Баянлиг, Гурванбулаг сумдын гэрээний хэрэгжилтийг хамгийн “бага” гэж үнэлсэн байна. (Хавсралт.6)

Баянхонгор аймгийн Засаг даргын сумдын Засаг даргатай 2024 онд байгуулсан 2024/01-2024/20 дугаартай гэрээний 13.3-т “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх” арга хэмжээг зургаадугаар хавсралтад заасан хүрэх түвшний үзүүлэлтээр үнэлнэ гэж заасан боловч дараах 3 шалгуур үзүүлэлтийг нэгтгэн дүгнэж, үнэлгээ өгсөн тул “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний үр дүнг үнэлэх боломжгүй байна. Үүнд:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх (Тарьсан мод, суулгацын тоо)
2. Гэр хорооллын нүхэн жорлонг бууруулж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх
3. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг байна.

Иймээс цаашид “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт тус бүрд үнэлгээ өгч, дүгнэх нь зүйтэй байна.

²² “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг холбогдох нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллага, албан тушаалтан хариуцдаг байх”

²³ “Тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгах”

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс сумдын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнтэй холбоотой арга хэмжээний биелэлтийг үнэлж, 7 сум нь “Бүрэн хэрэгжсэн”, 13 сум нь “Хэрэгжих шатанд” гэж үнэлсэн байна.

Хүснэгт 9. Баянхонгор аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлсэн байдал (2022-2025 оны хагас жил)

Үнэлгээ	Үнэлгээний хувь	Сумын тоо	Эзлэх хувь
"Бүрэн хэрэгжсэн"	90<100	7	0.35
"Хэрэгжих шатанд"	50<90	13	0.65
"Хэрэгжилт хангалтгүй"	10<50	0	0.00
"Хэрэгжээгүй"	0<10		

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс ирүүлсэн аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээд “Тэрбум мод” арга хэмжээтэй холбоотой заалтын хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээ

Баянхонгор аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний явцын хэрэгжилтийг аймгийн БОГ болон хэрэгжүүлэгч байгууллагууд байгууллагын цахим хуудас, сошиал орчноор тогтмол мэдээлж байгаа боловч аймгийн ЗДТГ-ын ХШҮХ нь жил бүрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтийг Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 3.1.2²⁴ дахь заалтын дагуу олон нийтэд мэдээлээгүй байна.

Иймд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан, дүгнэлтийг Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 3.1.2 -т заасны дагуу олон нийтэд ил тод, тогтмол мэдээлж байхыг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т зөвлөв.

БҮЛЭГ 3. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСЭЭС “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ЖИЛ БҮР ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ГАРГАСАН БОЛОВЧ ТҮҮНИЙ ДАГУУ ХОЛБОГДОХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

3.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтэд хяналт шалгалтын байгууллагуудаас хяналтыг хэрэгжүүлсэн байна.

3.1.1. Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01 тогтоолоор батлагдсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.5-т “Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт, шинжилгээ үнэлгээг БОАЖЯ, Ойн газар, “Монголын ойн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл” ТББ болон бусад байгууллагуудын оролцоотойгоор 2025, 2029 онуудад 2 удаа хийнэ” гэж төлөвлөжээ.

Баянхонгор аймгийн хэмжээнд аймгийн БОГ, аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс, БОНХОБТХ болон сумдын шат шатны мэргэжилтнүүд мод тарих, ургуулах, арчлах, хамгаалахтай холбоотой хяналтыг гүйцэтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны А/78 дугаар захирамжаар “Засгийн газрын тэргүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж, зөвлөмж боловсруулах” ажлын хэсэг байгуулж, “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд 2022-2024 он, 2025 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд 20 сумдын Ногоон байгууламж (мод тарих) ажлыг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын

²⁴ Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт ил тод байх”

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2022 онд боловсруулж баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 14 дүгээр хавсралтын дагуу үнэлж, ХШҮХ-ээс дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж ажилласан боловч “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд илэрсэн зөрчилд зөвлөмж гаргаж байгаа боловч тус зөвлөмжийн мөрөөр ямар ажил зохион байгуулсныг эргэж тооцдоггүй байна. (Хавсралт 7)

Дээрх журмын 5.3.3-т заасны дагуу сумдын 2022-2024 он, 2025 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн “Засгийн газрын тэргүүлэх төсөл, арга хэмжээний 1-р заалт “Ногоон байгууламж (Мод тарих)” арга хэмжээг үнэлэхэд Шинэжинст суманд хэрэгжүүлж буй мод тарих арга хэмжээ “Үр дүнтэй”, 8 сумын хэрэгжилт “Тодорхой үр дүнд хүрсэн”, 11 сумдад хэрэгжүүлж буй мод тарих арга хэмжээг “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлсэн байна.


Хүснэгт 10. Засгийн газрын тэргүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ, Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх журмын 5.3.3-ын дагуу үнэлсэн байдал (Ногоон байгууламж 2022-2025 оны хагас жил)

Үнэлгээ	Үнэлгээний хувь	Сумын тоо	Эзлэх хувь
"Үр дүнтэй"	100	1	0.05
"Тодорхой үр дүнд хүрсэн"	70<100	8	0.40
"Эрчимжүүлэх шаардлагатай"	30<70	11	0.55
"Үр дүнгүй"	0<30		

Эх сурвалж: ХШҮХ-ийн 2022-2025 оны хагас жилд Засгийн газрын тэргүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн илтгэх хуудас, тайлан мэдээ

Аудитын явцад сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч болон мэргэжилтнүүдийг хамруулан 63 албан тушаалтнаас санал асуулга авсан болно.

Дүрслэл 1. Санал асуулгын дүн



Дээрх санал асуулгын дүнгээс харахад ажлын гүйцэтгэл, ургалт болон мод тарих явцад сумын зүгээс тогтмол хяналт хийдэг гэж санал асуулгад оролцогчдын 39 хувь хариулсан, тарьц суулганын чанар, үрсэлгээ, дасан зохицох чадварт хяналт хэрэгжүүлдэг гэж 18 хувь нь хариулсан бөгөөд сумдад мод тарих, ургуулах, арчлах явцад тавих хяналт хангалтгүй гэж 34 хувь нь хариулсан ба хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дийлэнх нь тарьсан модны ургалтын хувь хангалтгүй байдаг, гүйцэтгэгч гэрээнд заасан үүргээ биелүүлж, ажлыг бүрэн гүйцэтгээгүй зөрчил илэрдэг гэж хариулжээ.

Шийдвэрлэлт: Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 дугаар тушаалаар баталсан журмын 4.3²⁵-д заасны орон нутгийн төсвөөс

²⁵ Гүйцэтгэгч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээний дагуу улсын төсвөөс санхүүжсэн ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн мэдээ, тайланг Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн төсвөөс санхүүжсэн ажлын мэдээ, тайланг холбогдох аймаг, нийслэлийн БОГ-т гэрээнд заасан хугацаанд ирүүлнэ.

санхүүжүүлсэн ажлын мэдээ, тайланг авч, хяналтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг аймгийн БОГ-т хүргүүлэв.

3.1.2. Баянхонгор аймгийн БОГ-аас улс, орон нутгийн төсвөөр санхүүжүүлсэн ойжуулалтын арга хэмжээний хэрэгжилтэд хяналт хийж, илэрсэн зөрчилд гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд зөвлөмжийг хүргүүлсэн боловч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 03 дугаар сарын 14-ний 01 дүгээр тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний ҮЧҮ-6: Байгаль орчны тэнцлийг хангах арга хэмжээний 25-т “Орон нутаг дахь Ойн анги, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих” заалт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ болон Ойн газрын улс орон даяар хэрэгжих 2024 оны А/10 тушаалаар батлагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих тухай Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 01/785 дугаартай албан бичиг хүргүүлсний дагуу, Ойн газар болон аймгийн БОГ-аас төлөвлөгөөт хяналтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

- 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж, Ойн газраас хэрэгжүүлсэн “Богд суманд ойн зурвас байгуулах” ажил гүйцэтгэх гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр байгуулж, гэрээнд заасны дагуу 2024 оны 10 дугаар сарын 19-нд Ойн газар болон Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын хамтарсан баг дээж талбайн тооллого хийхэд 23 хувьтай буюу ургалт хангалтгүй байсан тул аймгийн БОГ-аас 7 зөвлөмжийг гүйцэтгэгч компанид хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч, хариу ирүүлээгүй байна.
- Бууцагаан сумын Хамтын цэцэрлэгт хүрээлэнд 2024 онд “Түйн голын төгөл” ХХК нь улсын төсвийн санхүүжилтээр 6 га талбайд 12000 ширхэг 2 төрлийн модны суулгац тарих, 6000 ширхэг улиас модыг тарих ажлыг аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/598 дугаар захирамжаар томилсон ажлын хэсэг 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн ажлын мод тооллогын актаар гүйцэтгэгчид 4 зөвлөмжийг хүргүүлсэн боловч зөвлөмжийн биелэлтийг хүргүүлж ажиллаагүй байна.
- Баянхонгор аймгийн БОГ-с жил бүр сумдад ажиллан, хяналтыг хэрэгжүүлсэн боловч хяналт шалгалтын хүрээнд илэрсэн нийтлэг зөрчил, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулж байгууллагуудад хүргүүлээгүй байна.

Шийдвэрлэлт: Хяналтаар илэрсэн зөрчилд зөвлөмж боловсруулж сумдад хүргүүлж байх, хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийг тооцож, хяналт шалгалтын ажлын үр нөлөөг нэмэгдүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн БОГ-т хүргүүлэв.

3.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модыг улсын нэгдсэн цахим сан болон НББ-д бүрэн тусгаагүй байна.

3.2.1. Баянхонгор аймаг, сумын хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оноос 2025 оны эхний хагас жилийн байдлаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, төсөл хөтөлбөр, иргэн, аж ахуйн нэгжийн хандив зэрэг эх үүсвэрээр нийт 6,760.5 сая төгрөгийн хөрөнгө бий болсноос 1,250.0 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөөр, 2,843.9 сая төгрөгийн хөрөнгийг бараа материал болон зардлаар бүртгэж, 810.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

Гэрээний дүнг задлан харуулах боломжгүй нийт 1,856.2 сая төгрөгийн 9 гэрээ, үүнээс УТХО-аар санхүүжүүлсэн 1,397.7 сая төгрөгийн 5 гэрээ, ОНТХО-аар санхүүжүүлсэн 458.5 сая төгрөгийн 4 гэрээ байна.

Хүснэгт 11. Ойжуулалттай холбоотой төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгүүд (сая.төг)

№	Хөрөнгийн нэр, төрөл	Мөнгөн дүн
1	Модны тарьц, суулгац худалдан авах	2,688.4

2	Хайс хамгаалалт хийх	903.6
3	Усалгааны систем авах	689.3
4	Худаг гаргах	292.2
5	Тоног төхөөрөмж худалдан авах	189.1
6	Барилга байгууламж	102.8
7	Хүлэмж	38.9
8	Дүнг задлан харуулах боломжгүй ойжуулалттай холбоотой ажил	1,856.2
Дүн		6,760.5

Эх сурвалж: Гүйцэтгэлийн аудитын явцад авсан судалгааны нэгтгэл

Сангийн сайдын "Журам батлах тухай" 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-т тарьсан модыг бүртгэхтэй холбоотой тодорхой заалт байгаагүй байснаас байгууллагууд үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, бараа материал, бусад хангамжийн материал дансанд харилцан адилгүй бүртгэсэн байна.

Харин 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс өмнө мөрдөгдөж байсан Сангийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/229 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", Сангийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-д төсвийн хөрөнгөөр худалдан авч тарьсан модны бүртгэлийг тодорхой заасан байгаа ч төсөвт байгууллагууд дагаж мөрдөөгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Бөмбөгөр сумын ЗДТГ нь 2022 онд ОНХС-ийн хөрөнгөөр "Орчны тохижилт ногоон байгууламж бий болгох" ажлын хүрээнд "Түйн голын төгөл" ХХК-аас худалдан авсан 20.0 сая төгрөгийн модны тарьц суулгацыг "Ногоон байгууламж" нэрээр үндсэн хөрөнгөөр бүртгэж, элэгдэл тооцсон;
- Богд сум "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.
- Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн мөчрөөр тариалж байсан бургас, улиас модны талбайн хэсэгт 2024 онд 3 удаагийн үер орж, дахин ургах боломжгүй болсныг нягтлан бодох бүртгэлээс хасаж бүртгээгүй;
- Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн үрийн нөөцийн үлдэгдлийг тоолоход ойн техникчийн ирүүлсэн үрийн үлдэгдлийн мэдээтэй таарч байгаа бөгөөд харганы үрийн үлдэгдэл нягтлан бодогчийн хөрөнгө материалын орлого зарлагын дэлгэрэнгүй бүртгэлд 10 кг, нийт 1.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Иймд төсвийн болон хандивын хөрөнгөөр бий болсон модыг нягтлан бодох бүртгэлд УСНББОУС-ын дагуу үнэн зөв бүртгэх, нягтлан бодох бүртгэлийн арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст зөвлөв.

Шийдвэрлэлт: Байгалийн гамшгийн улмаас үерт урссан, бүртгэлд зөрүүтэй илэрхийлсэн, элэгдэл тооцсон тарьц суулгацыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн нягтлан бодох бүртгэлд залруулах, хасах албан шаардлагыг Бөмбөгөр сумын ЗДТГ, аймгийн Сум дундын ойн ангид хүргүүлэв.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, төсөл хөтөлбөр, ААН-ийн хөрөнгөөр "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд бий болсон 810.4 сая төгрөгийн 15 нэр төрлийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймагт 2022 онд улсын төсвийн 1,000.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Түмэн мод цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж" ажлын хүрээнд 4 багц бүхий тендер зарлагдаж ажлууд хийгдсэн бөгөөд "Хүрэн жинсний овоо" ХХК-ийн 2022 онд гүйцэтгэсэн 751.9 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий БАГЦ-2 "Түмэн мод цөлжилттэй тэмцэх ажил" -ын үр дүнд бий болсон хөрөнгүүдийг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хүлээн авч ашиглалтад оруулсан, дээрх хөрөнгөнд эзэмшигчийг тогтоох шийдвэр гараагүй, НББ-д бүртгээгүй;
- Баян-Овоо сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилтээр 2023 онд "Эм Жи Ти Ти Ти" ХХК-аас нийлүүлсэн 7.7 сая төгрөгийн усалгааны систем, иргэн Г-ийн хийж гүйцэтгэсэн 12.3 сая төгрөгийн модон хайс хамгаалалтыг хүлээн авч ашиглалтад оруулсан, тус хөрөнгүүдийг орлогод авч бүртгээгүй;

- Галуут сумын ЗДТГ нь 2023 онд "Гэрэлт ирээдүйн хөгжил" хоршооны хийж гүйцэтгэсэн 7.2 сая төгрөгийн хайс хамгаалалтыг орлогод авч бүртгээгүй;
- Эрдэнэцогт сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд "Чорьжбүрд" ХХК-ны хийж гүйцэтгэсэн 12.4 сая төгрөгийн худаг, 2024 онд "Грийнмайд" ХХК-ны нийлүүлсэн 7.0 сая төгрөгийн усалгааны систем зэрэг хөрөнгүүдийг НББ-д бүртгээгүй;
- Бөмбөгөр сумд нийгмийн хариуцлагын хүрээнд 2022 онд "Ай Эн Ди" ХХК-ийн хийж өгсөн 4.9 сая төгрөгийн хашааны хамгаалалтын тор, "Вояжер минерал ресурсес" ХХК-ийн 2024 онд хийж өгсөн 2.9 сая төгрөгийн худгийн хамгаалалтын байр, 2025 онд өгсөн 1.9 сая төгрөгийн худгийн насос, 14.4 сая төгрөгийн усалгааны систем зэрэг нийт 24.1 сая төгрөгийн хөрөнгүүдийг хүлээж аваагүй, бүртгэлд бүртгээгүй;

Баянхонгор аймагт 2022 онд улсын төсвийн 1,000.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Түмэн мод цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж" ажлын хүрээнд 4 багц бүхий тендер зарлагдаж БАГЦ-3 "Инженерийн хийцтэй уст цэг байгуулах" 94.5 сая төгрөгийн өртөг бүхий 3 худгийн бүртгэлийг 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар тодруулан үзэхээр шийдвэрлэв.

Төсвийн болон төсөл хөтөлбөр, хандивын хөрөнгөөр санхүүжүүлж хүлээн авсан хөрөнгүүдийг эзэмшигч тогтоох шийдвэрийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ хөрөнгө хүлээн авсан холбогдох байгууллага, алба нэгжээс хөрөнгөтэй холбогдох баримт материал мэдээллийг авч анхан шатны бүртгэл үүсгэн бүртгэлд тусгадаг байх шаардлагатай байна.


Шийдвэрлэлт: Дээрх хөрөнгүүдэд эзэмшигч тогтоох шийдвэр гаргуулж хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх 5 албан шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

3.2.2. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд тарьсан модны мэдээллийг оруулдаг www.terbummod.mn цахим системд нэвтрэх боломжгүйгээс улсын нэгдсэн санд модыг бүртгэх ажил зогссон байна.

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн нь 2030 он хүртэл 1.0 тэрбум мод тарих, ургуулах, хамгаалах зорилготой бөгөөд энэ ажлын хэрэгжилтийг бүртгэх, хянах олон нийтэд ил тод мэдээлэх зорилгоор 2023 оноос "<https://terbummod.mn/>" мэдээллийн системийг хөгжүүлж иргэн, аж ахуй нэгж байгууллага тарьсан модоо тус цахим хуудсаар тарьсан мод, төсөл арга хэмжээний ерөнхий мэдээллийг бүртгүүлэх боломжийг олгосон ч 2024 оны 12 дугаар сараас шинэ мэдээлэл ороогүй байна.

Баянхонгор аймгийн хувьд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны тоо, мэдээллийг terbummod.mn цахим системд оруулж, бүртгүүлэх эрхийг Ойн газраас 2023 оны 02 дугаар сард аймгийн БОГ-ын ойн мэргэжилтэнд өгсний дагуу 2022 онд тарьсан модны тоо, мод үржүүлгийн газруудын тарьц суулгац, ажиллах хүч, тоног төхөөрөмжийн мэдээллийг мэдээлсэн байна. Гэвч 2024 оноос тус системийг ашиглах боломжгүй болж холбогдох асуудлыг хөндсөн ч шийдэгдээгүй гэсэн тайлбарыг холбогдох мэргэжилтэн өгсөн болно.

Дүрслэл 2. Баянхонгор аймгийн хэмжээнд terbummod.mn сайтад мод бүртгэсэн байдал



Баянхонгор аймгийн тарьсан модны тоо terbummod.mn цахим системд 266,248 мод бүртгэлтэй гэж харагдаж байгаа боловч энэ тоо нь хэдэн онд, оруулсан мэдээлэл болох нь тодорхойгүй байна. Мөн тус цахим системийн "мод тарих" цэсээр ороход мод тарих төсөл арга хэмжээний ерөнхий мэдээлэл харагдаж байгаа боловч тус төсөл арга хэмжээ хэдэн онд хэрэгжихээр мэдээлэгдсэн эсэх нь тодорхой бус байна.

Эх сурвалж: terbummod.mn цахим хуудаснаас

Е-Mongolia цахим системээр дамжуулан 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс иргэд тарьсан модоо бүртгүүлэх, 2025 оноос иргэн, аж ахуй нэгж байгууллага нь тарьсан модоо Тэрбум Мод Нийгэмд үйлчлэх Төрийн бус байгууллагын www.billiontreesmongolia.com цахим сайтын “мод бүртгүүлэх” цэсээр орж бүртгүүлэх боломжтой болсон байна.

Е-Mongolia цахим системээр 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс иргэд тарьсан болон ургуулсан модоо бүртгүүлэх боломжийг олгосон ч мод, бутлаг ургамлын төрөл зүйлийн сонголт, тарьсан мод, бутлаг ургамлын нэрийн сонголтоос хамаарч мод тарьсан байршлын сонголтод одоогоор Баянхонгор аймгийн цөөхөн сумд, зарим сонголтод Баянхонгор аймаг байхгүй байна.

Иргэн, аж ахуй нэгж байгууллага нь тарьж ургуулсан модоо бүртгүүлэх боломжгүй байгаа тул холбогдох системүүдийн хөгжүүлэлтийг хийж, тарьж ургуулсан модоо бүртгүүлэх талаар мэдээлэл өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, улмаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд иргэд байгууллагуудыг идэвхтэй оролцохыг уриалах, урамшууллын системийг ижил арга замаар, нэг эх үүсвэрээс олгодог болох зэрэг олон асуудлуудыг шийдэх шаардлагатай байна.

Аудитаар нийт 1,160.2 сая төгрөгийн 33 зөрчил илрүүлж, 1,160.2 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах 20 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар 13 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

---оОо---

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Баянхонгор аймгийн хэмжээнд мөрдөх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлаагүй байна.
2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлж тарьж ургуулсан модны арчилгаа, усалгаа, хамгаалалт хангалтгүй, хариуцах эзэнгүйгээс ургалтын хувь бага байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байна.
3. Баянхонгор аймаг 2022-2025 оны эхний хагас жилийн байдлаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2030 он хүртэлх хугацаанд тарихаар амласан нийт модны 2.6 хувийг буюу 517,725 мод тарьсан гэж тайлагнасан боловч газар дээр нь тулган баталгаажуулаагүй байна.
4. Баянхонгор аймгийн ИТХ-ын 6 дугаар ээлжит хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу “Ойн биологийн олон янз байдлын төв” НҮТББ-ийн гүйцэтгэсэн цөлжилтийн судалгааг тайланг хүлээн авч, сумдад хүргүүлэх ажлыг аймгийн БОГ хэрэгжүүлээгүй байна.
5. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр тарьц, суулгацыг тарихаар төлөвлөхдөө усалгаа, хамгаалалтын асуудлыг хамтад нь шийдээгүй, модыг хүлээн авсны дараах арчилгаа, усалгаа, хамгаалалт эзэнгүйдсэнээс төсвийн хөрөнгийн үр ашиг зорилтот түвшиндээ хүрээгүй байна.
6. Баянхонгор аймгийн БОГ нь цөлжилтийг сааруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ойжуулах арга хэмжээнд тарьсан модны ургалтын хувийг тогтоох, тарьсан модны тоог үнэн зөв мэдээлэх байдалд тавих хяналт хангалтгүйгээс аймгийн БОГ, сумдын ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс ирүүлсэн тарьсан мод, ургалтын хувийн тоон мэдээлэл зөрүүтэй байна.
7. Баянхонгор аймгийн БОГ-аас улс, орон нутгийн төсвөөр санхүүжүүлсэн ойжуулалтын арга хэмжээний хэрэгжилтэд хяналт хийж, илэрсэн зөрчилд гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд зөвлөмж хүргүүлсэн боловч зөвлөмжийн мөрөөр хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
8. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй ойжуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд гүйцэтгэх ажлын төрөл, санхүүжилтийн нөхцөл, тарих модны нас, тоо, нэр төрөл, тариалалтын талбайн хэмжээ, ургалтын хувь, ажлын байр нэмэгдүүлэх, хариуцлага тооцох талаар тодорхой тусгаагүй байна.
9. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг идэвхжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, байгальд ээлтэй, зөв хандлагыг төлөвшүүлэх зорилгоор хашаандаа өөрийн хөрөнгөөр мод тарьц ургуулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах, иргэдэд дэмжлэг үзүүлэх бодлогыг орон нутгийн хэмжээнд боловсруулаагүй байна.
10. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалтын арга хэмжээний “Шинэ суурьшлын бүсэд байгуулсан ойн зурвас, Мод үржүүлгийн газар, аймгийн ХХААГ-ын жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн плантаци”-ийн гэрээний үүргийн биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд Уур амьсгалын Үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоол, холбогдох судалгаануудад үндэслэн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн хэмжээнд батлах зайлшгүй шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА

1. Уур амьсгалын Үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г үндэслэн аймгийн хэмжээнд мөрдөх стратеги төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлж ажиллах.
2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ногоон байгууламжийг хүлээн авахдаа түүний арчлалт, хамгаалалтын асуудлыг бүрэн шийдэж байх.
3. Гэрээний 3 жилийн зорилтод түвшиндээ хүрээгүй “Шинэ суурьшлын бүсийн ойн зурваст 100,000 ширхэг үрслэгээний зориулалттай говийн өргөст мод тарих” төсөл арга хэмжээг орон нутагт ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх талаар аймгийн мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан хэлэлцэж, гэрээг дахин нягталж төсвийн үр ашгийг сайжруулах.
4. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийтийн талбай болон хашаандаа мод тарьж ургуулсан иргэн, аж ахуй нэгж, нөхөрлөл, байгууллагыг дэмжих, урамшуулах бодлого гаргаж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.МӨНХЖАРГАЛ ТАНАА

1. Баянхонгор аймгийн ИТХ-ын 6 дугаар ээлжит хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу “Ойн биологийн олон янз байдлын төв” НҮТББ-ийн гүйцэтгэсэн цөлжилтийн судалгаа, тайланг хүлээн авч, сумдад чиглэл хүргүүлж ажиллах.
2. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 дугаар тушаалаар баталсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын 3.2.5, 4.3, 4.5, 4.9 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж, сумдаас авч байгаа тоон мэдээллийг бодит байдалтай тулган шалгаж, үнэн зөв нэгтгэж тайлагнах.
3. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн мөрөөр өгсөн шийдвэрийн дагуу хариу ирүүлээгүй аж ахуйн нэгж, нөхөрлөлд гэрээ, хууль, тогтоомжийн дагуу хариуцлагыг тооцох.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА У.БАЛЖИННЯМ ТАНАА

1. “Велотрейд” ХХК-тай байгуулсан гэрээний зах зээлд нийлүүлэх суулгацын нэр төрлийг олшруулах, нутагшуулах, сумдын ногоочдыг сургаж дадлагажуулах зэрэг гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН БОНХОБТХ-ЫН ДАРГА Г.ЭНХБАЯР ТАНАА

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойжуулалтын арга хэмжээг гүйцэтгэгчтэй байгуулах “Жишиг гэрээ”-г холбогдох хууль, тогтоомжийн дагуу боловсруулж сум, байгууллагуудад хүргүүлэх.
2. Сумдын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгасан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг аймгийн БОГ-ын тоон мэдээлэлтэй тулган баталгаажуулах.

СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА А.БАТАА ТАНАА

1. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 дугаар тушаалаар баталсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын 3.3-т заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр тарьц, суулгацыг тарихдаа тарих талбай, усалгаа, хамгаалалтын асуудлыг хамтад нь шийдэж, модыг хүлээн авсны дараа хариуцах албан тушаалтныг тодорхой болгож байх.
2. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 дугаар тушаалаар баталсан журмын 4.5, 4.9-т заасны дагуу санхүүжилтийг олгож, ажлыг хүлээн авч байх.